

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ 2020

ННА-60.6
ДАА-310
Д-475

СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА ХИЙХЭД ОРОЛЦОГЧИД

ХЯНАСАН:

Авирмэдийн Амарбал	Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга
Банзрагчийн Оюун	НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн хөтөлбөрийн менежер
Ням-Очирын Должинсүрэн	Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн албаны ахлах статистикч
Мягмарсүрэнгийн Дуламжав	ШУТИС-ийн багш-судлаач, Нийгмийн бодлогын хүрээлэн ТББ-ын судлаач
Даш-Очирын Ганчимэг	“Өлзий-Иш” ХХК-ийн зөвлөх, ТББ-ын зөвлөх, судлаач

БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН:

Ням-Очирын Должинсүрэн	Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн албаны ахлах статистикч
Даш-Очирын Ганчимэг	“Өлзий-Иш” ХХК-ийн зөвлөх, ТББ-ын зөвлөх, судлаач

Сэдэвчилсэн судалгаа нь 2020 оны ХАОСТ-ын жендэр монографын мэдээллийг агуулсан, илүү өргөн хүрээг хамарсан бөгөөд англи хэл дээр орчуулагдсан юм.

Уг судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр
Утас: (976-11)-321433, (976-11)-326414
Лавлах утас: 1900-1212
Цахим хуудас: www.nso.mn
Цахим хаяг: information@nso.mn

ISBN: 978-99978-758-8-4

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	4
Зургийн жагсаалт	5
Товчилсон үгийн тайлбар	8
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ	
ХУРААНГУЙ	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ	
ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТАЛААРХ НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ, МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ	15
ГУРАВДУГААР БҮЛЭГ	
ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ӨРХ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН БАЙДАЛ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ	23
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ	
ЭРҮҮЛ МЭНД, ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ	39
ТАВДУГААР БҮЛЭГ	
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ	51
ЗУРГААДУГААР БҮЛЭГ	
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЭРХ МЭДЭЛ, ШИЙДВЭР ГАРГАЛТ	71
ХАВСРАЛТ. ХҮСНЭГТҮҮД	83

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Жендэр ба хүйс хоорондын ялгаа	17
Хүснэгт 3.1	Өрхийн тоо, өрхийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он	28
Хүснэгт 3.2.	Өрхийн ам бүлийн дундаж тоо, өрхийн хэлбэр, өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршлаар, 2020 он	30
Хүснэгт 3.3	өрхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйс, хот, хөдөөгөөр, 2020 он	31
Хүснэгт 3.4.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, өрхийн хэлбэр, хот, хөдөө, хувиар, 2010, 2020 он	32
Хүснэгт 3.5.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, боловсролын түвшин, хувиар, 2010, 2020 он	35
Хүснэгт 3.6.	Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, сууцны эзэмшлийн хэлбэр, сууцны төрөл, хот, хөдөө, хувиар, 2020 он	36
Хүснэгт 4.1.	Нас баралтын түвшин (10000 хүнд ногдох), зонхилох өвчний төрөл, хүйс, насны бүлэг, байршлаар, 2019 он	44
Хүснэгт 5.1.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хүйсээр, хувиар, 2010, 2020 он	52
Хүснэгт 5.2.	Арван тав, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хот, хөдөө, хүйсээр, хувиар, 2020 он	52
Хүснэгт 5.3.	Зургаа, түүнээс дээш насны хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хүйс, бүс, аймаг, нийслэлээр, 2020 он	53
Хүснэгт 5.4.	Хоёроос таван насны хүүхдийн тоо, цэцэрлэгт хамрагддаг эсэх, нас, хүйсээр, 2020 он	54
Хүснэгт 5.5.	Цэцэрлэгт хамрагддаг 2-5 насны хүүхдийн тоо, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2020 он	55
Хүснэгт 5.6.	Сургуульд суралцдаг 6-15 насны хүүхэд, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2020 он	55
Хүснэгт 5.7.	Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, нас, хүйс, хот, хөдөөгөөр, 2010, 2020 он	57
Хүснэгт 5.8.	Зургаагаас арван таван насны хүүхдийн сургууль завсардалт, насны бүлэг, бүс, аймаг, нийслэлээр, хувиар, 2020 он	66
Хүснэгт 5.9.	Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он	67
Хүснэгт 5.10.	Арав, түүнээс дээш насны боловсролтой хүн амын эзлэх хувь, хүйс, насны бүлгээр, 2010, 2020 он	68

Зураг 3.1	Хүн амын тоо, өсөлтийн хувь, 1900-2019 он	24
Зураг 3.2	Хүн амын хүйсийн харьцаа, 1900-2020 он	24
Зураг 3.3	Хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2020 он	25
Зураг 3.4	Хүн амын дундаж наслалт, хүйсээр	25
Зураг 3.5	Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 2020 он	26
Зураг 3.6	Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр, 2019 он	26
Зураг 3.7	Монгол Улсын өрх, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр, хувиар, 2020 он	27
Зураг 3.8	Хот, хөдөөгийн өрхийн өсөлт, өрхийн тэргүүлэгчийн хүйс, өрхийн хэлбэрээр, 2010-2020 он	29
Зураг 3.9.	Өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсийн суварга, хувиар, 2010, 2020 он	29
Зураг 3.10.	Эрэгтэй болон эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн харьцаа, хувиар, 2000, 2010, 2020 он	30
Зураг 3.11.	Хаа-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, өрхийн тэргүүлэгчийн насны бүлэг, хүйсээр, мянган төгрөгөөр, 2019 он	32
Зураг 3.12.	Өрх толгойлсон, салсан* эцэг, эхийн хувь, насны бүлгээр, 2010, 2020 он	33
Зураг 3.13.	Өрх толгойлсон эцэг, эх, насны бүлгээр, хувиар, 2010, 2020 он	33
Зураг 3.14.	Өрх толгойлсон эцэг, эхийн нас, хүйсийн суварга, 2010, 2020 он	34
Зураг 3.15.	Өрх толгойлсон эцэг, эхийн нас, хүйсийн суварга, байршлаар, 2010, 2020 он	34
Зураг 3.16.	Өрх толгойлсон эцэг, эх, гэр бүлийн байдлаар, хувиар, 2010, 2020 он	35
Зураг 3.17.	Өрх толгойлсон эцэг, эхийн боловсролын түвшний хүйсийн харьцаа, хувиар, 2000, 2010, 2020 он	36
Зураг 4.1.	Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2010-2019 он	40
Зураг 4.2.	Эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр, 2019 он	40
Зураг 4.3.	Эрүүл мэндийн салбарт ажиллагчдын тоо, хүйсээр, 2010-2019 он	41
Зураг 4.4.	Хүйсийн харьцаа, тооллого явагдсан оноор	41
Зураг 4.5.	Төрөлт, нас баралт, 2010-2019 он	42
Зураг 4.6.	Төрөлт, нас баралт, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2019 он	42
Зураг 4.7.	Нийт нас баралт, 1000 хүнд ногдох түвшин, сонгосон оноор	42
Зураг 4.8.	Хүн амын нас баралт, 1000 хүнд ногдох түвшин, хүйсээр, 2010-2019 он	43
Зураг 4.9.	Хүн амын нас баралтын хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2010, 2019 он	43
Зураг 4.10.	Хүн амын нас баралтын түвшин, хүйсээр, аймаг, нийслэлээр, 2019 он	43
Зураг 4.11.	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгээр нас баралт, 10000 хүнд ногдохоор, хүйсээр, 2019 он	44
Зураг 4.12.	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгээр нас баралт, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2019 он	45

Зураг 4.13.	Спиртэд санамсаргүй хордож нас барсан тохиолдлын түвшин 10000 хүнд ногдохоор, хүйсээр, 2010-2019 он	45
Зураг 4.14.	Спиртэд санамсаргүй хордож нас барсан хүний тоо, 10000 хүнд ногдохоор, хүйсээр, 2019 он	46
Зураг 4.15.	Зам, тээврийн ослоор нас баралтын түвшин, 10000 хүнд ногдохоор, хүйсээр, 2010-2019 он	46
Зураг 4.16.	Зам, тээврийн ослоор нас баралтын түвшин, 10000 хүнд ногдохоор, насны бүлэг, хүйсээр, 2019 он	47
Зураг 4.17.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он	47
Зураг 4.18.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, бэрхшээлийн төрөл, хүйс, хувиар, 2010, 2020 он	48
Зураг 4.19.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, аймаг, нийслэлээр, дүнд эзлэх хувиар, 2010, 2020 он	48
Зураг 4.20.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, бэрхшээлийн хэлбэрээр, 2010, 2020 он	49
Зураг 5.1.	Хүн амын бичиг үсгийн мэдлэг, хувиар, сонгосон оноор	52
Зураг 5.2.	Цэцэрлэг, СӨБ-д хамрагдсан хүүхэд, сонгосон оноор	54
Зураг 5.3.	Хоёроос таван насны хүүхэд, хүйсээр, цэцэрлэгт хамрагддаг эсэх, хувиар, 2010, 2020 он	54
Зураг 5.4.	Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, хувиар, 2000, 2010, 2020 он	56
Зураг 5.5.	Зургаагаас арван нэгэн насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, хот, хөдөөгөөр, хувиар, 2020 он	58
Зураг 5.6.	Зургаагаас арван нэгэн насны хүүхдийн сургуульд хамрагдалт, хүйс, хувиар, 2020 он	58
Зураг 5.7.	Арван хоёроос арван таван насны хүүхдийн суурь боловсролд хамрагдалт, хүйс, хот, хөдөөгөөр, хувиар, 2020 он	59
Зураг 5.8.	Зургаагаас хорин есөн насны хүн амын сургуульд хамрагдалт, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2020 он	59
Зураг 5.9.	ЕБС-ийн өдрөөр суралцагчид, анги, хүйсээр, 2019/2020 оны хичээлийн жилд	60
Зураг 5.10.	ТБМБСБ-д суралцагчдын тоо, хүйсээр, 2010-2020 он	60
Зураг 5.11.	ТБМБСБ-д суралцагчид, суралцаж буй салбар, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2019/2020 оны хичээлийн жилд	61
Зураг 5.12.	ТБМБСБ-ын нийт төгсөгчдийн тоо, хүйсээр, 2010-2020 он	61
Зураг 5.13.	Их, дээд сургууль болон ТБМБСБ-д суралцаж буй эмэгтэй суралцагчдын эзлэх хувь, боловсролын зэргээр, 2002-2019 он	62
Зураг 5.14.	Их, дээд сургууль, коллежид суралцагчид, хүйсээр, 2010-2019 он	62
Зураг 5.15.	Их, дээд сургууль, коллежид суралцагчид, мэргэжлийн ерөнхий чиглэлээр, хүйсээр, 2010, 2019 он	62
Зураг 5.16.	ТБМБСБ, ИДС-д суралцагчдын хүйсийн харьцаа, 2010-2020 он	63
Зураг 5.17.	Бүх шатны боловсролын байгууллагын үндсэн багш, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010-2020 он	64
Зураг 5.18.	Сургууль завсардсан хүн амын нас, хүйсийн суварга, 2010, 2020 он	65
Зураг 5.19.	Сургууль завсардсан 6-15 насны хүүхэд, хүйс, бүсээр, 2020 он	65

Зураг 5.20.	Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, хувиар, 2020 он	67
Зураг 5.21.	Дээд болон тусгай мэргэжлийн дунд боловсролтой хүн амын нас, хүйсийн суварга, 2010, 2020 он	68
Зураг 5.22.	Арван тав, түүнээс дээш насны тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой хүн ам, насны бүлэг, хүйсээр, хувиар, 2010, 2020 он	69
Зураг 6.1.	Ажиллагчид болон ажилгүй иргэдийн тоо, сонгосон оноор	72
Зураг 6.2.	Ажиллагчид болон ажилгүй иргэдийн тоо, хүйсээр, сонгосон оноор	72
Зураг 6.3.	Ажиллагчид болон ажилгүй иргэдийн хүйсийн харьцаа, сонгосон оноор	73
Зураг 6.4.	Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, 2019 он	73
Зураг 6.5.	Ажиллах хүчний оролцооны түвшин, гэрлэлтийн байдал, хүйсээр, 2019 он	74
Зураг 6.6.	Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, сонгосон оноор	74
Зураг 6.7.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хот, хөдөөгөөр, хүйсээр, 2019 он	74
Зураг 6.8.	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, боловсролын түвшин, хүйсээр, 2019 он	75
Зураг 6.9.	Ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2019 он	75
Зураг 6.10.	Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2019 он	76
Зураг 6.11.	Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2019 он	76
Зураг 6.12.	Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2019 он	77
Зураг 6.13.	Ажилгүйдлийн түвшин, хүйсээр, сонгосон оноор	77
Зураг 6.14.	Ажилгүй хүн, насны бүлэг, хүйсээр, хувиар, 2019 он	78
Зураг 6.15.	ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, 2010-2019 он	78
Зураг 6.16.	УИХ-д нэр дэвшигчдийн тоо, хүйсээр, нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгуулийн оноор	79
Зураг 6.17.	УИХ-д сонгогдсон гишүүдийн тоо, хүйсээр, сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгуулийн оноор	79
Зураг 6.18.	Аймаг, нийслэлийн ИТХ-д нэр дэвшсэн хүний тоо, хүйсээр, нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймгаар	80
Зураг 6.19.	Аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон хүний тоо, хүйсээр, ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймгаар	80
Зураг 6.20.	Сумын ИТХ-д сонгогдсон хүний тоо, хүйсээр, сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, аймгаар	81
Зураг 6.21.	Улаанбаатар хотын дүүргийн ИТХ-д сонгогдсон хүний тоо, хүйсээр, сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, дүүргээр	81
Зураг 6.22.	Засгийн газрын сайд, дэд сайдын тоо, хүйсээр, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сонгосон оноор	81

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АТ	Ажилгүйдлийн түвшин
АХОТ	Ажиллах хүчний оролцооны түвшин
АХС	Ажиллах хүчний судалгаа
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ИДС	Их, дээд сургууль
МУ	Монгол Улс
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТБМБСБ	Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ХЭТ	Хөдөлмөр эрхлэлтийн түлшин
ШУ	Шинжлэх ухаан

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХУРААНГУЙ

МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮД



Бид **1677.3** мянга

МОНГОЛ ЭРЭГТЭЙЧҮҮД



Бид **1619.6** мянга



Бид
дунджаар
76 насалдаг



Бид
дунджаар
66 насалдаг



Бидний **5** хүн
тутмын **1** нь
дээд
боловсролтой



Бидний **16%** нь
дээд
боловсролтой



Бидний **5.4%**
нь өрх
толгойлсон эх



Бидний **0.9%** нь
өрх толгойлсон
эцэг

ХУРААНГУЙ

- Монгол Улсын хүн ам 1900-аад оны үед 600 гаруй мянга байсан бол өдгөө 2020 оны байдлаар 3.3 саяд хүрээд байна.
- ХАОСТ-ын 2020 оны дүнгээс харахад Монгол Улсын хүн амын хүйсийн харьцаа 96.6 болж, 100 эмэгтэйд 97 эрэгтэй ногдож байна.
- Хүн амын дундаж наслалтыг 1992 онд анх тооцоход улсын хэмжээнд 62.8 байсан бол 2019 онд төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь 70.4 болжээ.
- Манай улсын хүн амын дундаж наслалт 2018 оны байдлаар 69.7 болж, дэлхийн 185 орноос 127¹-д орж байна. Түүнчлэн дундаж наслалтын зөрүүгээр эхний 13-т оржээ.
- Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл 2020 оны байдлаар эмэгтэйчүүдийнх 76.0, эрэгтэйчүүдийнх 66.4 болж, эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 9.6 болов.
- Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 897.4 мянган өрх тоологдсон бөгөөд нийт өрхийн 641.5 буюу 71.5 нь хувь эрэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа бөгөөд өмнөх тооллогын үеэс 7.0 пунктээр буурч, харин 255.9 мянга буюу 28.5 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна.
- Гэрт амьдардаг өрхийн 5.1 хувь, байшинд амьдардаг өрхийн 10.2 хувь өөрийн гэсэн сууцгүй байгаагийн дийлэнх хэсгийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бүрдүүлж байна.
- Сүүлийн 11 жилийн хугацаанд 55-64 насны хосын дунд салалт 2.5 дахин өссөн байна.
- Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад ганц бие эрэгтэй, эмэгтэйчүүд хотод 82.0 орчим хувь өссөн байхад хөдөөд ганц бие эрчүүд 2 дахин өсжээ.
- Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр харахад эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлого эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлогоос 173.7 (29.0 хувь) мянган төгрөгөөр илүү байна.
- Улсын хэмжээнд өрх толгойлсон эцэг, эхийн тоо 105.6 мянга болж, 2010 оны тооллогын үеийнхээс 25.8 (21.7 мянга) хувиар нэмэгдсэний дотор өрх толгойлсон эхийн тоо 31.5 (21.8 мянга) хувиар өссөн бол өрх толгойлсон эцгийн тоо 1.0 хувиар буурчээ.
- Өрх толгойлсон эцэг, эхийн 13.8 хувь нь эрэгтэйчүүд, 86.2 хувь нь эмэгтэйчүүд байна.
- Эрүүл мэндийн салбарт 2019 оны байдлаар нийт 54687 ажиллагчид ажиллаж байгаа бөгөөд тэдний 44807 буюу 81.9 хувь нь эмэгтэйчүүд байна.
- Манай улсын хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа ойролцоогоор 100 охинд 105 хөвгүүн байх хандлага хадгалагдсаар байна. Харин 2019 оны байдлаар нас барж байгаа 100 эмэгтэйд 161 эрэгтэй ногдож байна.
- 2019 онд Монгол Улсын хүн амын тоонд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 49.1, эмэгтэйчүүдийнх 50.9 байгаа бол нас баралтанд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 61.7, эмэгтэйчүүдийнх 38.3 хувь байна.
- Хүн амын нас баралтын түвшин аль ч хүйсийн хувьд буурсан хэдий ч эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин эмэгтэйчүүдийнхээс 2.6 пунктээр их байна.
- Нас баралтын түвшинг хүйсээр харвал бүх аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.4-3.0 пунктээр илүү байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн нас баралтын түвшин харьцангуй өндөр байна.
- Нас баралтын түвшин 2019 оны байдлаар бүх өвчний төрөлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байгаа бөгөөд гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг болон амьсгалын тогтолцооны өвчнөөр эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин эмэгтэйчүүдийнхээс 2-4 дахин их байна.

1 "Human Development Report 2019" UNDP. 10 December 2019

- Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2.8 мянган гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын тохиолдол бүртгэгдэж, үүний 80.0 гаруй хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.
- Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 10000 хүнд ногдох түвшинг хүйсээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 4.2 дахин их байна.
- Сүүлийн 10 жилийн дунджаар спиртэд санамсаргүй хордож нас барсан тохиолдлын 83.6 хувь нь эрэгтэйчүүд байна.
- Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгээр нас баралтын 2 дахь шалтгаан болсон зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тохиолдол сүүлийн 10 жилийн дунджаар 556 бүртгэгдсэний 77.7 хувь нь эрэгтэйчүүд байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 46.2 хувь, эмэгтэйчүүдийн 45.3 хувийг 45-64 насныхан эзэлж байгаа нь хамгийн их байна. Харин 65 болон түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.8 дахин их байгаа нь эмэгтэйчүүд өндөр насалдагтай холбоотой юм.
- Монгол Улсын 15 болон түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг 1921 онд 2.1 хувь байсан бол 1944 онд 27.3 хувь, 1956 онд 70.5 хувь болж огцом өсөж, 1979 онд 92.7 хувь, 2010 онд 98.3 хувь, 2020 онд 98.7 хувь болж өсжээ.
- 2020 оны ХАОСТ-ын дүнгээр 2-5 насны нийт 312.1 мянган хүүхэд байгаагаас 262.5 буюу 84.1 хувь нь цэцэрлэгт хамрагдаж, 15.9 хувь нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна. Өмнөх тооллогын үетэй харьцуулахад цэцэрлэгийн тоо 1.7 дахин нэмэгдсэн ч цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо 2.2 дахин өсжээ.
- Цэцэрлэгт хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцааг харвал 100 охин тутамд 113 хөвгүүн ногдож байна. Бүх насанд хөвгүүдийн тоо охидоос илүү байна.
- Бага сургуульд суралцаж байгаа хүүхдүүд Монгол Улсад оршин суугаа Монгол Улсын харьяат 6-11 насны хүн амын 97.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллогын дүн (85.7)-гээс 12 пунктээр нэмэгдсэн сайн үзүүлэлт байлаа.
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор суурь боловсролд хамрагдаж байгаа 186.5 мянган хүүхэд байгаа бөгөөд хүйсийн харьцаа 103.8 байна.
- Ахлах ангийн сурагчдын 45.3 хувь нь хөвгүүд 54.7 хувь нь охид байна.
- 2019/2020 оны хичээлийн жилд ТБМБСБ-д нийт 37.8 мянган суралцагч хамрагдсан бөгөөд тэдний 22.3 мянга буюу 58.9 хувь нь эрэгтэйчүүд байна.
- Сүүлийн 4 жилийн хугацаанд ТБМБСБ-ыг төгсөгчдийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ төгсөгчдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь ихсэж 60.0-аас дээш хувь болжээ.
- Түүнчлэн их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй эмэгтэй суралцагчдын эзлэх хувийг харвал бакалавраас дээш зэрэгт суралцагчдын 55.0-аас дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчдын 47.0 хүртэлх хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.
- 2019/2020 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид нийт 148.4 мянган оюутан суралцаж байгаа бөгөөд суралцагчдын 90.6 мянга буюу 61.0 хувь нь эмэгтэйчүүд байна.
- 2019/2020 хичээлийн жилд ИДС-ийн 100 эмэгтэй суралцагчид 64 эрэгтэй суралцагч ногдож байна. Энэ харьцаа 2014 оноос хойш тасралтгүй буурсан байна.
- 2019/2020 оны хичээлийн жилд СӨБ-д ажиллаж буй үндсэн багш нарын 96.8 хувь нь эмэгтэй, ЕБС-ийн багш нарын 81.5 хувь эмэгтэй, ТБМБСБ-ын багш нарын 64.9 хувь нь эмэгтэй, ИДС-ийн багш нарын 61.3 хувь нь эмэгтэйчүүд байна.
- Нас ахих тутам сургууль завсардагчдын эзлэх хувь буурч байна. Харин 15 насанд бага зэрэг өссөн бөгөөд тэднийг хүйсээр харахад ихэнх хувь (72.1 хувь)-ийг хөвгүүд эзэлж байна.

- АХС-гаар 2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1146.2 мянган ажиллагч байгаа бөгөөд энэ нь ажиллах хүчний 90.0 хувь байна. Харин 127.7 мянган ажилгүй иргэд байгаа нь ажиллах хүчний 10.0 хувьтай тэнцүү байна.
- Ажиллагчдын 50.0-53.0 хувь нь, ажилгүй иргэдийн 46.0-58.0 хувь нь эрэгтэйчүүд байна.
- Динамикаас харахад ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувьд онцын өөрчлөлт гарч хэлбэлзсэнгүй, зөвхөн 2005 онд 49.5 хувь болж байжээ. Харин ажилгүй иргэдийн тоо 2010 он болон 2016-2019 онуудад 100.0 мянгаас дээш гарсан байна.
- 2010 онд болон 2014 оноос хойш ажилгүй 100 эмэгтэйд 130-аас дээш эрэгтэй ногдож байна. Энэ харьцаа 2016 онд хамгийн өндөр түвшинд хүрч, 164 болжээ.
- АХОТ бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс их байна. Түүнчлэн 25-29 болон 55-59 насны бүлэгт эрэгтэйчүүдийн АХОТ эмэгтэйчүүдийнхээс 23.3-29.3 пунктээр их байна.
- 18, түүнээс дээш насны хүн амын АХОТ-г гэрлэлтийн байдалтай холбож үзвэл бэлэвсэн хүн ам (хүйсийн хувьд ялгаа багатай)-ын хувьд АХОТ хамгийн доогуур буюу 26.6 хувь байна.
- Ажиллагч 10 хүн тутмын 3 нь бакалаврын болон дипломын дээд боловсролтой байна. Энэ хандлага эмэгтэй ажиллагчдын хувьд хадгалагдаж байсан бол эрэгтэй ажиллагчдын хувьд 10 хүн тутмын 3 нь техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшжээ.
- Тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажиллагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 61.4, докторын зэрэгтэй ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 78.7 хувь байна.
- Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, барилга, уул уурхай, олборлолт зэрэг салбарт ажиллагчдын дийлэнх буюу 79.6-86.5 хувь нь эрэгтэйчүүд байгаа бол бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын дийлэнх (56.6-84.3 хувь) нь эмэгтэйчүүд байна.
- Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, зэвсэгт хүчний ажил, мэргэжил, суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч мэргэжлээр ажиллагчдын 68.3-95.1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Харин мэргэжилтэн, худалдаа болон контор, үйлчилгээний ажил мэргэжлийн ажлыг дийлэнхдээ (62.1-78.8 хувь) эмэгтэйчүүд хийж байна.
- Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүний ажил хийж байгаа иргэдийн 70.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.
- Эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй ажиллагчдынхаас 2019 онд 201.4 мянган төгрөг буюу 19.7 хувиар их байна. Эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын цалингийн зөрүүг өмнөх онтой харьцуулахад 4.4 мянган төгрөгөөр нэмэгджээ.
- Монгол Улсын эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 83.5 хувь байгаа нь дэлхийн дунджаас дээгүүр боловч 2015 онтой харьцуулахад 5.2 пунктээр буурсан байна.
- Сонгуульд нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2004 оноос эхлэн огцом өсөж, 10.0 хувиас дээш гарсан байна.
- УИХ-д нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш бага байгаа бөгөөд 2012 онд хамгийн их буюу 32.0 хувьд хүрч байжээ.
- УИХ-ын гишүүн болсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2004, 2008 онд буурч, 2008 онд 3.9 хувь болж байсан бол сүүлийн жилүүдэд өсөж, 17.1 хувьд хүрсэн эерэг дүр зурагтай байна.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 7 удаагийн сонгуульд нийт 16 хүн нэр дэвшиж байснаас 2013 оны сонгуульд 1 эмэгтэй нэрээ дэвшүүлж байжээ.
- Сүхбаатар, Ховд, Булган, Дорноговь аймгаас аймгийнхаа ИТХ-д нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн их (24.6-27.7 хувь), харин Архангай, Дархан-Уул аймгаас нэр дэвшигчдийн дунд


эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага (11.8-13.2 хувь) байна.

- Нийслэлийн 2020 оны ИТХ-д нийт 205 хүн нэрээ дэвшүүлснээс 85 эмэгтэй байгаа бөгөөд нийт нэр дэвшигчдийн 29.3 хувийг эзэлж байгаа нэлээд нааштай үзүүлэлт юм.
- Аймаг, нийслэлийн ИТХ нь нийт 817 мандаттай бөгөөд нийт мандатын 131 буюу 16.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.
- Дорноговь, Архангай, Төв аймгийн ИТХ-д сонгогдсон нийт хүний 21.2-24.4 хувийг эмэгтэйчүүдийн эзэлж байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Харин Увс аймгийн ИТХ-д суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага буюу 9.8 хувь өөрөөр хэлбэл, 10.0 хувь ч хүрэхгүй байна.
- Сэлэнгэ, Дорноговь, Төв, Дархан-Уул аймгийн сумдын ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 36.0-40.2 хувь байна. Харин зөвхөн Баян-Өлгий аймгийн сумдын ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь (15.8 хувь) 20.0 хувьд ч хүрэхгүй байна.
- Хан-Уул, Баянзүрх дүүргийн ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага буюу 17.1-18.6 хувь байна. Харин Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Багахангай дүүргийн ИТХ-д сонгогдсон иргэдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 30.0-аас дээш байна.
- 2020 оны байдлаар Засгийн газрын сайд нарын түвшинд нийт сайдын 17.6 хувь, дэд сайдын 14.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол аймаг, нийслэлийн Засаг даргаар нэг ч эмэгтэй хүн ажиллаагүй байна.
- Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр бэлтгэн гаргадаг “Жендэрийн тэгш бус байдлын тайлан 2020”²-д дурдсанаар Монгол Улс 2020 онд Жендэрийн ялгаатай байдлын индекс (Gender Gap Index)-ээр дэлхийн 153 орноос 79-т эрэмбэлэгдэж (GGI-0.706), 2018 онтой харьцуулахад 0.007 оноогоор буурч, 21 байраар ухарчээ.

2 Global Gender Gap Report 2020, World Economic Forum, 2019

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТАЛААРХ НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ, МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ



ЖЕНДЭР, ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТАЛААРХ НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ, МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ

Хүний нийгмийн хөгжлийн орчин цагийн хэрэгцээ нь хувь хүний эрхийг хүндэтгэх, ялангуяа хүнийг аливаа хэлбэрээр ялгаварлах, түүний дотор хүйсээр ялгаварлан гадуурхах явдлыг арилгах буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш эрх, тэгш байдлыг тогтоохыг шаардаж байна.

Жендэр гэдэг нь англи хэлээр илэрхийлсэн агуулга юм. Олон улсад хэрэглэдэг нийтлэг ойлголтоор жендэр нь тодорхой нэг соёл, иргэншил, газар нутаг, нийгэм, цаг хугацаанд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд нийгмийн зүгээс оноосон үүрэг, хариуцлага юм. Хүйс гэдэг нэр томъёо нь хүний биологийн шинж чанартай холбоотой учир тэдгээр шинж нь төрөлхийн уг чанарт хамаардаг, өөрчлөх боломжгүй байдаг. Жендэрийн тэгш байдал гэдэг нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх эрхтэйг илэрхийлдэг.

Жендэрийн тэгш байдал гэдэг нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх эрхтэйг илэрхийлдэг.

Монгол Улсын Их хурлаас 2011 онд баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021), НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны Эх дэлхийгээ шинэчилье, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэрэг баримт бичигт хөгжилд дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлснээр төрийн бүх шатны байгууллагад эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийг хангах, ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрийг устгах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх бодит шаардлага бий болсон билээ.

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд “жендэр” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг; “жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ” гэж заажээ.

Хүйс нь байгалиас заяагдмал бөгөөд хувиршгүй бол жендэр нь эмэгтэй, эрэгтэй хүний нийгэм, соёлын ялгааг тусгасан ойлголт бөгөөд нийгэмшдэг, түүхэн ёсоор өөрчлөгдөж байдаг. Жендэр бол эрэгтэй, эмэгтэй хүйс заасан ойлголт төдийн биш эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн байр суурийг илэрхийлсэн, хүний нэр төр, эрх мэдэл, мэргэжил боловсрол, эрх чөлөө зэрэг үнэт зүйлстэй нь шууд холбоотой ухагдахуун юм. Жендэр ба хүйс хоорондын зарим ялгааг дараах хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 2.1. ЖЕНДЭР БА ХҮЙС ХООРОНДЫН ЯЛГАА

Жендэр	Хүйс
Эмэгтэй, эрэгтэй хүнд нийгмээс оноосон үүрэг хариуцлага	Эрэгтэй, эмэгтэй хүний биологийн шинжүүд
Цаг хугацаанаас шалтгаалан өөрчлөгдөнө.	Байнгын/тогтсон шинжтэй, цаг хугацааны явцад өөрчлөгдөхгүй.
Өөр өөр соёл иргэншлийн хувьд ялгаатай.	Өөр соёл иргэншлийн хувьд ч ялгаагүй.
Боловсрол, орлогын түвшин, нас, нийгмийн гарал үүсэл, шашин болон бусад хүчин зүйлд нөлөөлдөг.	Эдийн засгийн, нийгмийн хүчин зүйлүүд нөлөөлөхгүй.
Зөвхөн эмэгтэйчүүдийн болон эрэгтэйчүүдийн дунд ч гэсэн тэдний нас, үндэс угсаа, орлогын түвшин, соёл, уламжлал болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ялгаатай байдаг.	Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд ижил.

Тухайлбал, эмэгтэйчүүд хүүхэд төрүүлж, эрэгтэйчүүд үр тогтоох чадвартай нь хүйсийн онцлог бөгөөд эмэгтэй хүн жирэмсэн болох, хүүхэд төрүүлэх, хүүхдээ хөхүүлэх нь эмэгтэй хүйсээс салгах аргагүй тул хүйсийн үүрэг юм. Харин жендэрийн үүрэг нь тухайн бүтэц, соёлоос хамааран эмэгтэй, эрэгтэйчүүдийн хүлээх үүрэг хариуцлагыг ялгаатайгаар оногдуулсан байгааг хэлдэг. Харин эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн ажлыг хийж чаддаг, мөн эрэгтэйчүүд хүүхэд асарч чаддаг нь жендэрийн онцлог юм.

Хүйсийн үүрэг өөрчлөгдөшгүй бол жендэрийн үүрэг нийгмийн өөрчлөлтийг дагаж өөрчлөгддөг. Нөгөө талаас бичил түвшин дэх жендэрийн үүрэгт гарсан өөрчлөлт нь нийгмийн макро түвшин дэх өөрчлөлтийг дагуулдаг.

Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгэм, биологийн нэлээд тогтвортой бичил хамтлаг учир хүний нийгмийн түүхэн явцад бүрэлдэн тогтож, түүний нөлөөнд автагдан бас түүний хөгжилд хүчтэй нөлөөгөө үзүүлсээр ирсэн бөгөөд энэ нь жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага хүчтэй илэрч, олон үр дагавар бий болгож байдаг орчин юм.

Жендэрийн статистик нь статистикийн бүх салбартай хамааралтай. Тэр нь жендэрийн асуудалд чиглэсэн шаардлагатай өөрчлөлтийг дэмжих хэрэгсэл юм. Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл нь зөвхөн хүйсээр ялгасан тоо гаргахын нэр биш, жендэрийн статистик нь жендэрийн ялгаа болон түүний асуудлын талаар системтэй судлах боломж олгодог. Хүйсээр ялган гаргасан тоо нь жендэрийн мэдрэмжтэй мэдээллийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Жендэрийн статистик нь нотолгоо/баримтад тулгуурласан судалгаа, бодлогын шийдлээр хангах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай нөхцөл байдлыг үнэлэх, түүнд гарч байгаа өөрчлөлтийг хянах, ахиц дэвшил, өөрчлөлтийг олон нийт, хэрэглэгчдэд мэдээлэхэд чухал бөгөөд статистикийн системийг бүхэлд нь боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, хүн амын үйл ажиллагаа, онцлог шинжийг илүү бодитой, бүрэн илэрхийлж харуулахад түлхэх хүч болдог³.

Жендэрийн статистикийн түүхээс сөхвөл, НҮБ-аас 1975 оныг “Олон улсын эмэгтэйчүүдийн жил” болгон зарлахын зэрэгцээ Мексикийн Мехико хотноо Дэлхийн эмэгтэйчүүдийн анхдугаар бага хурлыг зохион байгуулж, энэхүү анхдугаар чуулган эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл гаргах нь маш чухал ач холбогдолтой гэдгийг онцлон тэмдэглэж байжээ. Энэ хурлаас хойш статистикийн байгууллагууд эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийг цуглуулж эхэлсэн. НҮБ нь 1980 онд Дани улсын нийслэл Копенгаген хотноо дэлхийн эмэгтэйчүүдийн хоёрдугаар бага хурлыг, 1985 онд Кени улсын нийслэл Найробид дэлхийн эмэгтэйчүүдийн гуравдугаар бага хурлыг тус тус зохион байгуулж, гуравдугаар бага хурлын үеэр олон улсын статистикийн систем жендэрийн статистикийн мэдээлэл гаргах чиглэлээр илүү анхаарч ажиллах, тоо мэдээлэл гаргагч, бодлого боловсруулагчдын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой алхмуудыг хийхээр санал гаргасан. Энэ үеэс “эмэгтэйчүүд хөгжилд” гэсэн стратегийн ерөнхий зарчмаас “жендэр ба хөгжил” гэсэн шинэ үзэл баримтлал руу шилжсэн юм. Үүнтэй уялдан статистик ч

3 UNECE, “Developing Gender Statistics: A Practical Tool”, 2010

мөн “эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл”-ээс “эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээлэл” рүү шилжиж “жендэрийн асуудлуудыг статистикийн мэдээлэлд нэгтгэх үйл явц”-ыг эхлүүлсэн. Энэ үеэс НҮБ болон олон улсын бусад байгууллагаас нийгэм, эдийн засгийн хөгжилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ялгаатай үүрэг ролийг харуулах статистикийн мэдээллийг хэрхэн гаргах талаар заавар, зөвлөмж гаргаж, үндэсний хэмжээнд мөрдөж ажиллахыг зөвлөмж болгосон. Үүний үр дүнд БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо дэлхийн эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр бага хурал хуралдсан. 1995 он болоход олон орны үндэсний статистикийн байгууллага эрэгтэй, эмэгтэйчүүдийн талаарх статистик мэдээллээр ном, товхимол бэлтгэж хэрэглэгчдэд хүргэдэг болсон бөгөөд ойлголт, тодорхойлолт, мэдээлэл цуглуулалт, арга зүйгээ сайжруулах чиглэлээр нэлээд их хүчин чармайлт гаргасан нь харагдаж байлаа.

Бээжингийн бага хурал нь олон улсын болон үндэсний түвшинд жендэрийн статистикийг хөгжүүлэх шинэ хөдөлгөгч хүч болсон бөгөөд үүнээс хойш олон орны үндэсний статистикийн байгууллага жендэрийн статистикийн нэгж байгуулж, албан ёсны статистикийн мэдээлэл гаргахад бүхэлд нь жендэрийн асуудлыг нэгтгэн тусгах тусгай хөтөлбөр боловсруулан ажиллаж ирсэн⁴.

ЭРЭГТЭЙЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭГШ ЭРХ, ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООНЫ ХӨГЖИЛ

Бээжин хотноо 1995 онд хуралдсан Дэлхийн эмэгтэйчүүдийн бага хурлаас гаргасан Мөрийн хөтөлбөрт: Үндэсний механизм нь Засгийн газраас жендэрийн өргөн хүрээний асуудлыг нийгэм, эдийн засгийн нийт бодлогод тусгахыг дэмжиж, жендэрийн тэгш байдлын хэтийн төлвийг хангах үүрэг хүлээсэн төрийн бодлогыг уялдуулан зохицуулах үүрэг бүхий нэгж юм. Жендэрийн үндэсний тогтолцоо нь Засгийн газрын салбар байгууллагууд/яамд/-аар дамжуулан жендэрийн тэгш байдлыг хангах стратегийг хэрэгжүүлэх, бодлогоор дэмжих төдийгүй “өөрчлөлт хийх манлайлагч хүч юм” гэжээ.

Монгол Улс “Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай” болон “Хүүхдийн эрхийг хамгаалах” конвенци зэрэг хүний эрхийн 29 гэрээ конвенцид нэгдэн орсон билээ. Мөн “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах” 1992 оны Женевийн тунхаглалыг зөвшөөрсөн юм.

1921 ОНООС ӨМНӨХ ҮЕ

Ардын хувьсгалаас өмнөх үеийн Монголын нийгэмд эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажил, хөдөлмөр нарийн хуваарьтай, эцгийн эрхт ёс давамгайлж, нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралын нэлээд хэсэгт эмэгтэйчүүд хоёр дахь байр суурийг эзэлж байв. Олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо сул байсан тул шийдвэр гаргах түвшинд эрэгтэйчүүд давамгайлж байлаа. Шарын шашин нийгмийн амьдралд чухал байр суурь эзэлж, эрэгтэйчүүд олноороо сахил хүртэж байв. Энэ нь төрөлтийн бууралтад мэдэгдэхүйц нөлөөлж, хүн амын тоо цөөрөхөд хүргэжээ. Эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага зөвхөн гэр бүл, ах дүү, эх хүний үүрэг хариуцлагын хүрээнд хязгаарлагдаж байв⁵.

АРДЫН ХУВЬСГАЛААС ХОЙШИХ ҮЕ БОЛОН СОЦИАЛИЗМЫН ҮЕ

Монгол Улсын эмэгтэйчүүдийн аж байдалд 1921 оны ардын хувьсгал үлэмж их өөрчлөлт авчирсан юм. 1924 онд батлагдсан Монгол Улсын анхны Үндсэн хуульд “Тус улсын харьяат ард түмэн, иргэн угсаа, шашин, эрэгтэй, эмэгтэй гэдэг ялгаагүйгээр нэгэн адил эрхийг эдлүүлбэл зохино”⁶ гэж хүйсийн тэгш байдлыг тунхагласан байдаг. Энэ хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулж, бие хүнд эрх чөлөө олгож, гэрлэх хүнээ өөрсдөө сонгох эрхийг олгосон зэрэг өөрчлөлт гарчээ.

Монгол Ардын Намаас түмэнд тунхаглан зарлах бичигт монгол үндэсний төлөө зүтгэхийг хүссэн шударга

4 UNECE: Brief history of Gender statistics

5 НҮБ-ын тайлан, 2000

6 Монгол Улсын Үндсэн хууль, Баримт бичиг. УБ, 2004, 43 дахь тал

үнэнч хэнийг ч боловч нийгмийн гарал үүсэл, хүйс үл харгалзан намд элсүүлэхээр заасан нь монголын эмэгтэйчүүдийг улс төрийн хэрэгт оролцох үүд хаалгыг нээжээ.

“Бошгыг халах залуучуудын эвлэл” хэмээх нэртэй залуучуудын байгууллага 1921 оны 8 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдав. Тэр үед манай эмэгтэйчүүд шашны арга хэмжээнээс өөр хурал, цуглаанд оролцож үзээгүй, бичиг үсэг мэддэг нь цөөн байсан хэдий ч нийгмийн идэвхтэй эмэгтэйчүүд монгол бичиг үсэг төдийгүй түвд, манж, хятад, орос хэл сурч, мэдээлэл авч, шинэ цагийн суртал нэвтрүүлгийн ажилд оролцож байжээ. Хүн амын 49.1 хувийг эзэлж байсан эмэгтэйчүүдийг нийгэм, улс төрийн үйл хэрэгт татан оролцуулахын чухлыг нам, эвлэлийн гишүүд мэдэрч, энэ үйл ажиллагааг зохион байгуулж, эмэгтэйчүүдэд туслах байгууллага бий болгох тухай янз бүрийн санал, санаачилга гаргаж байлаа. Тухайлбал, 1922 онд хуралдсан бошгыг халах залуучуудын анх дугаар их хурал эмэгтэйчүүдэд тэгш эрх олгох тухай асуудлыг хэлэлцэж байсан ба залуу эмэгтэйчүүдийг нам, эвлэлд элсүүлэх, тэднийг хувьсгалын үйл ажиллагаанд оролцуулахад туслах, эмэгтэйчүүдийн байгууллага байгуулах шаардлагын тухай ярилцаж байжээ.

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1924 оны 3 дугаар сарын 8-ны хурлаас Монголын эмэгтэйчүүдийн байгууллагыг байгуулах тухай түүхт шийдвэр гаргаж, түүний дүрмийг боловсруулан гаргахыг МАХН-ын Төв Хорооны Суртлын хэлтэст даалгасан байна. Тэрхүү шийдвэрийн дагуу эмэгтэйчүүдийн байгууллагыг анх Монгол Улсын 14 дүгээр оны 2 дугаар сарын 13 буюу 1924 оны 3 дугаар сарын 19-нд “Бүсгүйчүүдийг боловсруулах тасаг” нэртэйгээр байгуулсан нь төрийн өмнө эмэгтэйчүүдийн хөгжил, нийгмийн оролцоог хариуцах, эхчүүд, охид, бүсгүйчүүдийн дунд олон нийтийн үйл ажиллагаа явуулах эрх үүрэг бүхий Монголын Эмэгтэйчүүдийн Хороо байгуулах суурь болж, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрх, тэгш байдлыг хангах үндэсний тогтолцооны эхлэл тавигдсан гэж үзэж болох юм.

Монгол Улсын Үндсэн хуульд 1940 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, улс орныхоо тусгаар тогтнол, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг улам бүр баталгаажуулсан бөгөөд Монгол Улсыг хөгжүүлэх нэг жилийн төлөвлөгөө баталж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхэлсэн түүхт он байлаа. Энэ үед Монголын эмэгтэйчүүдийн байгууллага Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг эмэгтэйчүүдэд таниулах, нэг жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн шинэ ажлыг зохион байгуулж байжээ.

МАХН-ын Улс Төрийн Товчооны 1961 оны 159 дүгээр тогтоолоор МАХН-ын Төв Хороонд байсан Эмэгтэйчүүдийн тасгийг Монголын эмэгтэйчүүдийн хороо гэж нэрлэх болов. Энэхүү тогтоолоор аймаг, хотын эмэгтэйчүүдийн зөвлөлөөр дамжуулан тэдний дунд соёл боловсрол, олон нийтийн ажил зохион байгуулахыг хариуцуулав. Энэ үеэс эмэгтэйчүүдийн нийгмийн байдал эрс өөрчлөгдөж, бараг бүх эмэгтэй бичиг үсэгтэй болсон төдийгүй төрөл бүрийн мэргэжилтэй эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсээр байлаа. Эрдмийн зэрэг цолтой эмэгтэйчүүд төрөн гарснаар эмэгтэйчүүдийн дунд соёл хүмүүжил, улс төрийн ажил явуулах боломж өргөжсөн байна.

Төрөөс 1960-1989 онд эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, боловсрол, бичиг үсэг тайлагдалт зэрэгт онцгойлон анхаарснаар хүйсийн ялгаа мэдэгдэхүйцээр багасчээ.

1990 ОНООС ХОЙШИХ ҮЕ

Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад манай улс 1990 оноос хуулийн шинэ орчинг бүрдүүлсэн юм. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд манай улсын эрэгтэй, эмэгтэй бүхий л иргэн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэйг баталгаажуулжээ. Түүнчлэн, ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настанг асрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох эрхийг нь хуульчилсан юм.

Төрийн байгууллага, холбогдох яамд 1992-1995 онд эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах асуудал болон “Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллаж байв.

Жендэрийн тэгш байдлын асуудал хариуцах Үндэсний зөвлөлийг 2000 онд байгуулж, 2005 он хүртэл “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байв. Тус зөвлөл 2005 оноос Жендэрийн тэгш байдлын Үндэсний Хороо болон өргөжиж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангах, “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах, хяналт-үнэлгээ хийх үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан.

Жендэрийн үндэсний хороо нь 2005 оноос эхлэн Ерөнхий сайдын удирдлага дор ажиллаж, үндэсний хэмжээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиг үүргийг хүлээж байсан.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрын тэргүүний хувьд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсны дагуу Жендэрийн үндэсний хороог тэргүүлэн ажилласаар байна. Түүнчлэн 2014 онд Монгол Улсын Засгийн газрын 382 дугаар тогтоолоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Жендэрийн ажлын албыг ажиллуулахаар тогтсон болно.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Дэлхийн улс орны удирдагчид, төрийн тэргүүн нар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2000 онд болсон тусгай чуулганд оролцохдоо хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй олон асуудлыг хэлэлцэн “Мянганы тунхаглал”-ыг батлан гаргасан. Энэхүү тунхаглалаар аль ч улс орны төрөөс ард иргэдийнхээ ая тухтай, аюулгүй, сайн сайхан амьдралын баталгааг хангахад хамгийн чухал суурь асуудал бол эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломжийг хангах, гэр бүл, нийгмийн харилцаанд тэдний эрхийг дээдэлж баталгаажуулах явдал хэмээн үзсэн юм.

Монгол Улсын төрөөс энэхүү “Мянганы тунхаглал”-ын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн орны онцлог байдлыг харгалзан улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн суурь нөхцөл бололцоог бүрдүүлэхэд ихээхэн анхаарч, Монгол Улсын Их Хурлаас “Мянганы хөгжлийн зорилт”-ыг хэлэлцэн баталж, түүнд суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын баримт бичгийг батлан 2000-2015 оны хооронд хэрэгжүүлсэн билээ. Энэхүү зорилтод жендэрийн асуудлыг тусгасан ч нийгэм, эдийн засгийн хөгжилд илүүтэй анхаарсан нь учир дутагдалтай байлаа.

Үүнээс үүдэн тогтвортой хөгжихийн үндэс нь хүнээ хөгжүүлэх, тэр дундаа хүйсийн тэнцвэрт байдлыг хангах нь гол түлхүүр болохыг анхаарсан.



Ингээд “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын “Тогтвортой хөгжил” бага хурлын үеэр санаачилсан. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж байсан “Мянганы хөгжлийн зорилтууд”-ын үргэлжлэл юм. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган болж, ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс “Тогтвортой хөгжлийн зорилго” (ТХЗ) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.

ТХЗ-ын 5 дахь зорилгод “Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах”-ыг зааж, нийт 9 зорилт бүхий 14 үзүүлэлтийг тодорхойлон, улс орнуудыг үнэлэх боломжоор хангасан юм.





Ийнхүү Монгол Улс ТХЗ-ыг хангах, хэрэгжилтийг үнэлэхэд хүчин чармайлт гаргаж, үндэсний хэмжээний мэдээллийг бий болгоход анхааран ажиллаж байна. Мөн түүнчлэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Гэсэн хэдий ч манай улсад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдах бодит байдалд тэгш бус хандлага ажиглагдаж буйг анхаарахгүй өнгөрч болохгүй. Энэ нөхцөл байдлаас улбаалж гэр бүлийн амьдрал, нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлэх, эрх нь зөрчигдөх явдал гарч байгааг анхаарах шаардлагатай байна. Иймээс “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд хяналт, үнэлгээ хийх, шаардлагатай мэдээллийг шинэчлэх, баяжуулах, түүнд үндэслэн хүйсийн нарийвчилсан судалгаа хийх шаардлага гарсаар байна.

Дээрх шаардлагад үндэслэн ҮСХ-ноос 10 жил тутам зохион байгуулдаг Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого, албан ёсны болон захирааны мэдээ, тайлан, мөн бусад судалгаа, мэдээллийн эх үүсвэрт үндэслэн хүн амын нас, хүйсийн бүтэц, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрх мэдэл, шийдвэр гаргалт зэрэгт хүйсийн ялгаатай байдлыг илрүүлж, түүнд тулгуурлан зарим дүгнэлт, бодлогын чанартай санал дэвшүүлэхэд судалгааны гол зорилго оршино.

ГУРАВДУГААР БҮЛЭГ


ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ӨРХ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН БАЙДАЛ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ



ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ӨРХ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН БАЙДАЛ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Монгол Улсын хүн ам 1900-аад оны үед 600 гаруй мянга байсан бол өдгөө 2020 оны байдлаар 3.3 саяд хүрээд байна. Хүйсээр харвал нийт хүн амын 1619.6 буюу 49.1 хувь нь эрэгтэй, 1677.3 буюу 50.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүн амын тоо болон өсөлтийн хувийг Зураг 3.1-д харуулсан бөгөөд манай улсын хүн амын өсөлт 1980-аад оны үед оргил цэгтээ хүрч байжээ.


ЗУРАГ 3.1 ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТИЙН ХУВЬ, 1900-2019 ОН



Тайлбар: 1918-2000, 2010, 2020 он нь тооллого явагдсан он

Харин хүн амын хүйсийн харьцааг сонгосон онуудаар харахад 1944 болон 2010 оны үед хүйсийн харьцаа хамгийн доод цэгтээ хүрч унасан байна. Энэ нь дэлхийн II дайн болон Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэний дараах үед эрэгтэйчүүдийн тоо нэлээд буурсныг харуулж байна. Хүн амын тоо өсөж байгаа хэдий ч хүйсийн харьцаа буурсаар байгааг доорх зургаас харж болно.


ЗУРАГ 3.2 ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА⁷, 1900-2020 ОН



ХАОСТ-ын 2020 оны дүнгээс харахад Монгол Улсын хүн амын хүйсийн харьцаа 96.6 болж, 100 эмэгтэйд 97 эрэгтэй ногдож байна. Энэ үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл төрөх үед хөвгүүд давамгайлдаг бол нас ахих тутам насны бүлэг дэх эрэгтэйчүүдийн тоо буурч, хүйсийн харьцаа тасралтгүй буурдаг байна.

7 Эрэгтэйчүүдийн тоог эмэгтэйчүүдийн тоонд харьцуулсан харьцаа бөгөөд энэ нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлнэ. "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал", УСХ, 2013


ЗУРАГ 3.3 ХҮН АМЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2020 ОН



Эндээс дүгнэхэд эрэгтэйчүүдийн нас баралт залуужиж байгаагийн дээр эмэгтэйчүүдийнхээс их байна.

Монгол Улс анх 1992 оноос эхлэн дундаж наслалтыг тооцож эхэлсэн. Хүн амын дундаж наслалтыг 1992 онд анх тооцоход улсын хэмжээнд 62.8 байсан бол 2019 онд төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь 70.4 болжээ.

ЗУРАГ 3.4 ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ⁸, ХҮЙСЭЭР




Дэлхийн улс орнуудын хувьд хүн амынхаа дундаж наслалаар Хонконг (84.7), Япон (84.5), Сингапур (83.8) зэрэг орнууд тэргүүлж байгаа бөгөөд өндөр хөгжилтэй орнуудын хүн амын дундаж наслалт 82-83 байна. Түүнчлэн Африк (Төв африкийн бүгд найрамдах улс-52.8, Чад-54.0, Нигер-54.3) тивийн улс орны хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу ойролцоогоор 53 байна. Харин манай улсын хүн амын дундаж наслалт 2018 оны байдлаар 69.7 болж, дэлхийн 185 орноос 127⁹-д орж байна. Түүнчлэн дундаж наслалтын зөрүүгээр эхний 13-т орж байгаа тул эрэгтэйчүүдийн дундаж наслалт бага байгаа шалтгааныг судалж, онцгой анхаарах шаардлагатайг харуулна. Африкийн орнуудын хүн амын дундаж наслалт бага байгаа хэдий ч эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү бага буюу 2-3 байна.

Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл 2020 оны байдлаар эмэгтэйчүүдийнх 76.0, эрэгтэйчүүдийнх 66.4 болж, эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 9.6 болов. Дундаж наслалтын энэхүү зөрүү нь 2013 оноос эхэлсэн бөгөөд энэ зөрүү нь буурахгүй хадгалагдсаар байна. Дундаж наслалтын зөрүү холдсоор байгаа нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал муу, нас баралт их байгаатай холбоотой юм.

8 Шинээр төрсөн (төрөх үеийн) хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацаа(жил)-г хэлнэ. “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал”, YCX, 2013 он


9 “Human Development Report 2019” UNDP. 10 December 2019

ЗУРАГ 3.5 ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, ХҮЙСЭЭР, 2020 ОН



Дундаж наслалтыг аймаг, нийслэлээр харахад Дундговь аймгийн хүн амын дундаж наслалт хамгийн их буюу 74.23 бол Хөвсгөл аймгийн хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу 67.09 байна. Хөвсгөл аймгийн хүн амын дундаж наслалт улсын дунджаас 3.3 насаар богино байна. Мөн түүнчлэн Дархан-Уул, Дорнод, Увс аймгийн хүн амын дундаж наслалт 70 хүрэхгүй байна. Зураг 3.6-д үзүүлсний дагуу аймгийнхаа хүн амын дундаж наслалт, эрүүл мэндэд анхаарч дундаж наслалт бусад аймгаас богино байгаагийн шалтгааныг судлах, эрэгтэй, эмэгтэй хүн амын дундаж наслалтын зөрүүнд үндэслэж бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаагаа төлөвлөж байх шаардлагатайг харуулж байна.

ЗУРАГ 3.6 ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН



Нийгмийн анхдагч нэгж нь хүн болон өрх тул эдгээр үзүүлэлтийг салшгүй байдлаар авч явах нь зүйтэй юм.

Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагддаг тооллого, судалгаанд өрхтэй холбоотой дараах нэгдмэл ойлголт, тодорхойлолтыг мөрдөж ажилладаг. Өрхийг “Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Нэг өрхөд хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно”¹⁰ гэж тодорхойлдог.

Өрх нь гэр бүлээс илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Өрх нь үндсэн өрх, хамт суудаг өрх, ам бүлээрээ байгаа өрх, нийлмэл ам бүлтэй өрх, холимог өрх гэсэн олон төрөлтэй байдаг. Харин гэр бүлийг эрх зүйн талаас “гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүд”¹¹ хэмээн тодорхойлж, гэр бүлийн гишүүнд “гэр бүл бологчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүн”-ийг хамруулан ойлгоно гэж дурджээ. Амьдрал дээр түгээмэл тохиолддог гэр бүлийн хэлбэр болох эхнэр, нөхөр, үр хүүхэдтэйгээ амьдрах, эсвэл эцэг, эх, хамаатан садангийн хамт 2 үеийн гэр бүл нэг дор амьдрах нь өрх, гэр бүл хэмээх ойлголтуудын адил талыг харуулдаг бол гэр бүлийн гишүүдийн дунд төрлийн болон садангийн хамааралгүй хүн амьдарч байгаа тохиолдлыг авч үздэгээрээ өрх нь гэр бүлээс илүү өргөн хүрээтэй ухагдахуун юм.

Өрх, гэр бүлийн түвшинд жендэрийн талаас нь судлах нь өрхийн тэргүүлэгчийн хүйс, нас, хөдөлмөр эрхлэлт, боловсрол эзэмшилт, амьдарч буй сууцны төрөл, нөхцөл цаашлаад гэр бүлийн гишүүдийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй уялддаг. Өрхийн тэргүүлэгчийн хүйсээс хамаараад өрхийн сайн сайхан амьдрах орчин, амьжиргааны эх үүсвэр, үр хүүхдийн хүмүүжил, сургуульд хамрагдалт, улмаар бие хүн болж төлөвших явдал зэрэг олон зүйлс ялгаатай байдаг. Тиймээс энэ хэсэгт өрх, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдлыг өрхийн тэргүүлэгчийн хүйсийн ялгаатай байдлаар харуулахыг зорив. Мөн өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэйчүүд, тэр дундаа эцэг, эхчүүдийн ялгаатай байдлыг тооллого, судалгаа болон бусад мэдээлэлд үндэслэн тодорхойлно.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор 897.4 мянган өрх тоологдсон байна. Нийт өрхийн 641.5 буюу 71.5 нь хувь эрэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа бөгөөд өмнөх тооллогын үеэс 7.0 пунктээр буурч, харин 255.9 мянга буюу 28.5 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна.

ЗУРАГ 3.7 МОНГОЛ УЛСЫН ӨРХ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН



Мөн 2010 онтой харьцуулахад өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо огцом (66.7 хувь) өсжээ. Нийт өрхийн 67.6 хувь нь хотод, 32.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Хотод амьдарч байгаа өрхийн хувь 2010 оны тооллоготой харьцуулахад 0.4 пунктээр нэмэгдсэн байна.

10 “Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал”, УЦХ, 2013

11 Гэр бүлийн тухай хууль, 3.1.2, 3.1.4 дүгээр заалт, www.legalinfo.mn

Өрхийн бүтцийн хувьд авч үзвэл 59.8 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 22.7 хувь нь нийлмэл¹² ам бүлтэй өрх, 15.4 хувь нь ганц бие өрх, 2.2 хувь нь холимог¹³ ам бүлтэй өрх байна. Өмнөх тооллогын дүнгээс ам бүлээрээ байгаа өрх 91.3 мянга буюу 20.5 хувиар, нийлмэл ам бүлтэй өрх 25.4 мянга буюу 14.3 хувиар, ганц бие өрх 61.9 мянга буюу 81.5 хувиар, холимог ам бүлтэй өрх 5.1 мянга буюу 33.9 хувиар тус тус өссөн байна (Хүснэгт 3.1).

Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо өсөхөд эмэгтэй тэргүүлэгчтэй ам бүлээрээ байгаа өрх 83.3 хувь, нийлмэл өрх 41.4 хувь, холимог өрх 81.1 хувь өссөн нь нөлөөлжээ. Харин эрэгтэй тэргүүлэгчтэй ганц бие өрх 90.0 хувиар өссөн нь анхаарал татаж байна. Ганц бие эрэгтэй, эмэгтэйчүүд нэмэгдсэн нь гэр бүл салалт их байгаатай холбоотой бөгөөд сүүлийн 11 жилийн хугацаанд 55-64 насны хосын дунд салалт 2.5 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 3.1 ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Үзүүлэлтүүд	Тоо		Хувь		2020 2010 %	
	2010	2020	2010	2020		
Бүгд	Бүгд	713 780	897 427	100.0	100.0	125.7
	Эрэгтэй	560 224	641 484	78.5	71.5	114.5
	Эмэгтэй	153 556	255 943	21.5	28.5	166.7
Ганц бие	Бүгд	75 917	137 826	100.0	100.0	181.5
	Эрэгтэй	42 278	80 329	55.7	58.3	190.0
	Эмэгтэй	33 639	57 497	44.3	41.7	170.9
Ам бүлээрээ	Бүгд	445 048	536 309	100.0	100.0	120.5
	Эрэгтэй	380 296	417 614	85.5	77.9	109.8
	Эмэгтэй	64 752	118 695	14.5	22.1	183.3
Нийлмэл	Бүгд	177 898	203 317	100.0	100.0	114.3
	Эрэгтэй	127 071	131 424	71.4	64.6	103.4
	Эмэгтэй	50 827	71 893	28.6	35.4	141.4
Холимог	Бүгд	14 917	19 975	100.0	100.0	133.9
	Эрэгтэй	10 579	12 117	70.9	60.7	114.5
	Эмэгтэй	4 338	7 858	29.1	39.3	181.1


Нийт өрхийн 10 өрх тутмын 6 нь ам бүлээрээ буюу эхнэр, нөхөр, хүүхдийнхээ хамт амьдарч байгаа өрх байна. Мөн нийлмэл ам бүлтэй, өөрөөр хэлбэл эцэг, эх, ах, дүүс, садан төрлөөрөө сууж байгаа бүтэцтэй өрх нэлээдгүй хувийг эзэлж байгаа нь үр хүүхэд, хамаатан садантайгаа хамт амьдрах нь манай уламжлалт заншилтай уялдаатай гэж үзэж болно.

Аймгийн төв, томоохон суурин газар болон нийслэлд нийгэм, соёлын үйлчилгээ хөдөөтэй харьцуулахад илүү байгаатай холбоотойгоор сүүлийн 20 жилийн хугацаанд хотжих үйл явц эрчимтэй явагдаж, нийт өрхөд хотын өрхийн эзлэх хувь 2000 оноос 2010 оны хооронд 12.4 пунктээр өссөн бол 2010 оноос 2020 оны хооронд бараг нэмэгдээгүй байна. Харин хот, хөдөөгийн өрхийн өсөлтийг өрхийн хэлбэрээр авч үзвэл ялгаатай зүйлүүд ажиглагдаж байна.

12 Хоорондоо хамааралтай хэд хэдэн ам бүл хамтран өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг нийлмэл өрх гэнэ.


13 Ураг төрлийн хамааралтай болон хамааралгүй хүмүүс өрх үүсгэн амьдарч байгаа тохиолдлыг холимог өрх гэнэ.

ЗУРАГ 3.8 ХОТ, ХӨДӨӨГИЙН ӨРХИЙН ӨСӨЛТ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010-2020 ОН




Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад ганц бие эрэгтэй, эмэгтэйчүүд хотод 82.0 орчим хувь өссөн байхад хөдөөд ганц бие эрчүүд 2 дахин өсжээ. Харин эмэгтэй тэргүүлэгчтэй ам бүлээрээ байгаа болон холимог өрхийн тоо хотод ойролцоогоор 2 дахин өссөн байна.

ЗУРАГ 3.9. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ХУВИАР, 2010, 2020 ОН



Өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсийн суваргыг Зураг 3.9-д байршлаар харуулав. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 25-аас дээш насанд өсөж, 15-24 насанд буурсан байна. Харин эрэгтэй тэргүүлэгчтэй өрх 15-29 насанд буурсан байна. Эндээс өрхийн тэргүүлэгчийг насны бүтцээр харвал өрхийн тэргүүлэгчийн нас нэмэгдэж байгааг харж болно.

ЗУРАГ 3.10. ЭРЭГТЭЙ БОЛОН ЭМЭГТЭЙ ТЭРГҮҮЛЭГЧТЭЙ ӨРХИЙН ХАРЬЦАА, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН



Улсын дүнгээр 2000 онд эрэгтэй тэргүүлэгчтэй өрх эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөөс 5.1 дахин, 2010 онд 3.6 дахин их байсан бол энэ харьцаа 2020 онд 1.1 пунктээр буурч 2.5 болов.

ХҮСНЭГТ 3.2. ӨРХИЙН АМ БҮЛИЙН ДУНДАЖ ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, БАЙРШЛААР, 2020 ОН

Үзүүлэлтүүд		Байршил		
		Бүгд	Хот	Хөдөө
Ам бүлээрээ	Бүгд	3.6	3.5	3.9
	Эрэгтэй	2.3	2.3	2.3
	Эмэгтэй	8.3	6.7	13.5
Нийлмэл	Бүгд	4.6	4.6	4.6
	Эрэгтэй	3.3	3.4	2.9
	Эмэгтэй	7.1	6.7	9.3
Холимог	Бүгд	4.9	5.0	4.4
	Эрэгтэй	4.0	4.1	3.3
	Эмэгтэй	6.4	6.4	6.9

Улсын хэмжээнд ам бүлээрээ амьдарч байгаа өрхөд дунджаар 4 хүн, нийлмэл өрхөд 5 хүн, холимог өрхөд 5 хүн ногдож байна. Үүнийг өрхийн тэргүүлэгчийн хүйс, байршлаар ангилж үзвэл нэлээд ялгаатай байдал харагдана. Тухайлбал, хотод ам бүлээрээ байгаа өрхийн ам бүлийн дундаж тоо хөдөөгийнхөөс бага байхад бусад хэлбэрийн хувьд хотод их байх хандлагатай байна. Өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилсан дүнгээс харахад эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эрэгтэй тэргүүлэгчтэй өрхөөс ам бүлийн тоогоороо нэлээд их байна. Энэ нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчидтэй харьцуулахад салсан, бэлбэсэн эмэгтэйчүүд өрх тэргүүлэн олноороо амьдарч байгаатай холбоотой юм.

Хүснэгт 3.3-т сууцны эзэмшлийн хэлбэрийг сууцны төрөл, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилж үзүүлэв. Нийт өрхийн 91.6 хувь нь өөрийн эзэмшлийн сууцтай бол үлдсэн 8.4 хувь буюу 74.9 мянган өрх бусдын сууцанд амьдарч байна. Эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 92.7 хувь, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн 89.2 хувь нь өөрийн гэсэн сууцтай юм. Бусдын сууц түрээсэлдэг, түрээсгүй ашигладаг аль ч тохиолдолд эмэгтэй тэргүүлэгчтэй өрх олон байна. Байршлаар нь авч үзвэл хотод өөрийн эзэмшлийн сууцтай өрх хөдөөтэй харьцуулахад бага, хотын эмэгтэй тэргүүлэгчтэй 10 өрх тутмын нэг нь байр түрээслэн амьдарч байна.

ХҮСНЭГТ 3.3 ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд			Гэр			Байшин			Бусад сууц		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД - Тоо	897 427	641 484	255 943	342 409	253 825	88 584	546 979	382 138	164 841	8 039	5 521	2 518
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	91.6	92.7	89.2	94.9	95.7	92.5	89.8	90.7	87.5	80.6	82.4	76.5
Бусдын сууцанд түрээстэй	3.7	3.2	4.8	1.7	1.4	2.5	4.9	4.4	6.0	6.0	5.0	8.2
Бусдын сууцанд түрээсгүй	4.4	3.9	5.7	3.2	2.7	4.7	5.0	4.6	6.1	12.3	11.6	13.9
Бусад	0.3	0.3	0.4	0.2	0.2	0.3	0.3	0.3	0.4	1.1	1.0	1.4
ХОТ - Тоо	606 282	408 931	197 351	149 873	97 876	51 997	451 638	307 978	143 660	4 771	3 077	1 694
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	90.2	91.1	88.3	91.8	92.7	90.1	89.8	90.7	87.8	81.7	83.9	77.6
Бусдын сууцанд түрээстэй	4.7	4.3	5.5	3.2	3.0	3.6	5.2	4.7	6.1	6.4	5.5	8.2
Бусдын сууцанд түрээсгүй	4.8	4.3	5.8	4.7	4.0	5.9	4.7	4.3	5.7	10.7	9.6	12.6
Бусад	0.4	0.3	0.4	0.4	0.4	0.4	0.3	0.3	0.4	1.2	1.0	1.6
ХӨДӨӨ - Тоо	291 145	232 553	58 592	192 536	155 949	36 587	95 341	74 160	21 181	3 268	2 444	824
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	94.7	95.3	92.0	97.3	97.7	95.9	89.8	90.9	86.0	78.9	80.4	74.3
Бусдын сууцанд түрээстэй	1.5	1.3	2.5	0.6	0.5	0.9	3.4	3.0	4.8	5.4	4.5	8.0
Бусдын сууцанд түрээсгүй	3.6	3.2	5.3	2.1	1.8	3.1	6.5	5.8	8.8	14.7	14.1	16.7
Бусад	0.1	0.1	0.2	0.1	0.0	0.1	0.3	0.3	0.3	1.0	1.0	1.0


Гэрт амьдардаг өрхийн 5.1 хувь, байшинд амьдардаг өрхийн 10.2 хувь өөрийн гэсэн сууцгүй байгаагийн дийлэнх хэсгийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бүрдүүлж байна. Гэхдээ хөдөөд гэр түрээслэн амьдрах явдал хоттой харьцуулахад бага, харин бусад төрлийн сууцыг түрээслэн амьдардаг өрх хотоос их байна.

Байшинд суудаг эрэгтэй тэргүүлэгчтэй хот, хөдөөгийн өрхийн 90.0 орчим (2010 онд 83-86 хувь) хувь нь өөрийн эзэмшлийн сууцтай байхад эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хувьд энэ үзүүлэлт байршлаар ялгаагүй 87.0 (2010 онд 77.0 хувь) орчим хувьтай байна. Эндээс харахад сүүлийн 10 жилийн хугацаанд өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн эзлэх хувь багагүй нэмэгдсэн байгаа нь улсаас авч хэрэгжүүлж байгаа “Дахин төлөвлөлт”, “Орон сууцжуулах хөтөлбөр, төсөл” зэргийн үр дүнд гарсан нааштай өөрчлөлт байж болох юм.

Харин эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бусдын сууцанд амьдрах явдал бусадтай харьцуулахад өндөр байгаа бөгөөд тэдний орлогыг нэмэгдүүлэх, хүний анхдагч хэрэгцээ болсон хямд, чанартай сууцаар хангах, зээлийн хүүгийн бодлогоор дэмжихэд цаашид үргэлжлүүлэн анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Түүнчлэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзвэл, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлого эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлогоос 173.7 (29.0 хувь) мянган төгрөгөөр илүү байна.

ЗУРАГ 3.11. ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, МЯНГАН ТӨГРӨГӨӨР, 2019 ОН



Эх үүсвэр: ҮСХ, ӨНЭЗС, 2019 он

Энэ хэсэгт өрх толгойлсон эцэг, эхийг тэдний ам бүл, хүүхдийн тоо, нийгэм, эдийн засгийн үзүүлэлттэй холбож судалсан. Энэ төрлийн судалгаанаас харахад өрх толгойлсон эх, түүний гэр бүлийн гишүүд өрх толгойлсон эцгийнхтэй харьцуулахад илүү эмзэг, ядууралд өртөмтгийг нотлон харуулсан байдаг. Хэдийгээр тооллогоор ядуурал, амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлт цуглуулаагүй боловч өрхийн тэргүүлэгчийн хөдөлмөр эрхлэлт, орон сууцны нөхцөл зэрэг үзүүлэлтээс зарим чухал дүгнэлтийг хийж болох юм.

Улсын хэмжээнд өрх толгойлсон эцэг, эхийн тоо 105.6 мянга болж, 2010 оны тооллогын үеийнхээс 25.8 (21.7 мянга) хувиар нэмэгдсэний дотор өрх толгойлсон эхийн тоо 31.5 (21.8 мянга) хувиар өссөн бол өрх толгойлсон эцгийн тоо 1.0 хувиар буурчээ. Өрх толгойлсон эцэг, эхийн 13.8 хувь нь эрэгтэйчүүд, 86.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт дүнгээрээ өрх толгойлсон эцэг, эхийн тоо хотод 28.5 хувиар, хөдөөд 18.9 хувиар өсөв.


ХҮСНЭГТ 3.4. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Үзүүлэлтүүд		Бүгд		Өөрчлөлт	Хот		Өөрчлөлт	Хөдөө		Өөрчлөлт
		2010	2020		2010	2020		2010	2020	
ТОО										
Бүгд	Бүгд	83 929	105 592	25.8	60 381	77 583	28.5	23 548	28 009	18.9
	Эрэгтэй	14 771	14 620	-1.0	9 942	10 024	0.8	4 829	4 596	-4.8
	Эмэгтэй	69 158	90 972	31.5	50 439	67 559	33.9	18 719	23 413	25.1
Ам бүлээрээ	Бүгд	52 281	65 908	26.1	34 501	45 166	30.9	17 780	20 742	16.7
	Эрэгтэй	9 058	8 908	-1.7	5 437	5 494	1.0	3 621	3 414	-5.7
	Эмэгтэй	43 223	57 000	31.9	29 064	39 672	36.5	14 159	17 328	22.4
Нийлмэл	Бүгд	29 727	36 808	23.8	24 364	29 716	22.0	5 363	7 092	32.2
	Эрэгтэй	5 411	5 246	-3.0	4 265	4 103	-3.8	1 146	1 143	-0.3
	Эмэгтэй	24 316	31 562	29.8	20 099	25 613	27.4	4 217	5 949	41.1
Холимог	Бүгд	1 921	2 876	49.7	1 516	2 701	78.2	405	175	-56.8
	Эрэгтэй	302	466	54.3	240	427	77.9	62	39	-37.1
	Эмэгтэй	1 619	2 410	48.9	1 276	2 274	78.2	343	136	-60.3
ХУВЬ										
Бүгд	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	17.6	13.8	-3.8	16.5	12.9	-3.5	20.5	16.4	-4.1
	Эмэгтэй	82.4	86.2	3.8	83.5	87.1	3.5	79.5	83.6	4.1
Ам бүлээрээ	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	17.3	13.5	-3.8	15.8	12.2	-3.6	20.4	16.5	-3.9
	Эмэгтэй	82.7	86.5	3.8	84.2	87.8	3.6	79.6	83.5	3.9
Нийлмэл	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	18.2	14.3	-3.9	17.5	13.8	-3.7	21.4	16.1	-5.3
	Эмэгтэй	81.8	85.7	3.9	82.5	86.2	3.7	78.6	83.9	5.3
Холимог	Бүгд	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0	100.0	100.0	0.0
	Эрэгтэй	15.7	16.2	0.5	15.8	15.8	0.0	15.3	22.3	7.0
	Эмэгтэй	84.3	83.8	-0.5	84.2	84.2	0.0	84.7	77.7	-7.0

Өрхийн хэлбэрээр ангилахад холимог өрхийн хэлбэрээр амьдарч байгаа өрх толгойлсон эцгийн тоо тооллого хооронд хамгийн ихээр (нийт дүнгээрээ 54.3 хувь) өссөн, харин бусад хэлбэрийн хувьд өрх толгойлсон эхийн тоо илүү өссөн байгаа нь гэр бүл салсны дараа насанд хүрээгүй хүүхдүүд ихэнхдээ эхийнхээ асрамжид үлдэж байгаатай холбоотой байна.

Өрх толгойлсон эцэг, эхийн тооны өөрчлөлтийг тэдний гэр бүлийн байдлаар ангилж харахад нэлээд зүйл тодорхой болж байна. Сүүлийн 11 жил орчмын хугацаанд салалт, ялангуяа 45-54 насанд ихээр, 55-64 насанд 2.5 дахин нэмэгдсэнтэй холбоотой ажээ.


ЗУРАГ 3.12. ӨРХ ТОЛГОЙЛСОН, САЛСАН* ЭЦЭГ, ЭХИЙН ХУВЬ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2020 ОН



*Тусгаарласан болон цуцалсан тохиолдлыг үүнд хамруулав.

Хэдийгээр 35-54 насны хос хамгийн ихээр салж байгаа хандлага тооллого хооронд хэвээр байгаа боловч дараагийн насны бүлэгт ийнхүү өссөн шалтгааныг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм. Өрхийн доторх ажил амьдрал жигдэрч, хат сууж туршлагажсан, үр хүүхэд нь өсч том болсон үед салалт ихээр нэмэгдсэн нь нэг талаас гэр бүлийн хүчирхийлэл, шилжилтийн үеийн зовлон бэрхшээл гэр бүлийн харилцаанд нөлөөлсөн, нөгөө талаас “дунд насныхны хямрал (middle life crisis)” буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийн идэр наснаас ахмад насанд шилжих үеийн биологийн өөрчлөлт (санаа зовнил, цэвэршилт, сэтгэл зүйн тогтворгүй байдал), ажилгүйдэл эсвэл ажлын хэт их ачаалалд дарагдах зэрэг нийгмийн болоод сэтгэлзүйн олон хүчин зүйлээс хамаарч байж болзошгүй юм.


ЗУРАГ 3.13. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ, НАСНЫ БҮЛГЭЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН



Өрхийн тоог өрхийн тэргүүлэгчийн хүйсээр ангилахад эрэгтэйчүүд давамгайлж байсан бол тэднийг гэр бүлийн байдал болон хүүхэдтэй эсэхээр нь ялгаж харвал өрх толгойлсон эхчүүд эцгүүдээс олон байна. Улсын дүнгээр 15-34 болон 55-аас дээш насанд өрх толгойлсон эцэг, эхчүүд хамгийн олноор нэмэгджээ. Дараагийн онцлог өөрчлөлт бол 15-34 насны өрх толгойлсон эцгийн хувь өмнөх тооллогын үеэс 4.9 пунктээр нэмэгдэж, 55-аас дээш насны өрх толгойлсон эхчүүдийн эзлэх хувь 7.9 пунктээр нэмэгдсэн явдал юм. Энэ нь эрэгтэйчүүдийн дундаж наслалт, нас баралттай холбоотой ажээ.

Өрх толгойлсон эцэг, эхийн голч нас 2000 онд 43.2 (эцэг 51.7, эх 41.0), 2010 онд 44.0 (эцэг 48.1, эх 43.3) байсан бол 2020 оны тооллогоор 46.1 (эцэг 49.2, эх 45.5) болж өсөв. Эрэгтэй тэргүүлэгчийн голч нас эмэгтэйгийнхээс өндөр байсан бол өрх толгойлсон эцгийн голч нас эхийнхээс бас илүү байгаа юм. 2010 онтой харьцуулахад өрх толгойлсон эцэг, эхийн голч нас өсөж, насны зөрүү ойртсон байна.

ЗУРАГ 3.14. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН




Суваргаас улсын хэмжээнд 25-34, 55-69 болон 75-аас дээш насанд өрх толгойлсон эхийн тоо өмнөх тооллогын үеэс нэлээд нэмэгдсэн нь тодорхой харагдана.

Харин өрх толгойлсон эцэг 20-34, 55-64 насанд бага зэрэг нэмэгджээ.


Нас, хүйсийн суваргыг байршлаар харвал хот, хөдөөд ялгаагүй 50-69 насны өрх толгойлсон эхчүүдийн тоо нэлээд нэмэгдсэн байна. Энэ нь эрчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 10 орчим насаар зөрүүтэй болсонтой холбоотой.

ЗУРАГ 3.15. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, БАЙРШЛААР, 2010, 2020 ОН



Харин хотод 20-34 насны өрх толгойлсон эх, ялангуяа 25-29 насанд илүү олноор нэмэгджээ. Харин 35-54 насанд буурсан дүнтэй байна.

ЗУРАГ 3.16. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХ, ГЭР БУЛИЙН БАЙДЛААР, ХУВИАР, 2010, 2020 ОН



Дээрх зургаас харахад өрх толгойлсон эцгийн тоо тооллого хооронд буурсан, түүнчлэн салсан болон бэлбэсэн эцэг, эхийн хувийн жин 2010 онтой харьцуулахад нэлээд ихээр буурчээ. Харин огт гэрлээгүй өрх толгойлсон эцэг, эхийн хувийн жин тус бүр 12.3, 11.4 пунктээр нэмэгджээ.

Эхнэр нь нас барснаас хойш дахин гэрлээгүй буюу бэлбэсэн эцгийн хувийн жин 7.7 пунктээр, эхийнх 4.5 пунктээр буурчээ. Эндээс дүгнэхэд хүнтэй гэр болохгүйгээр хүүхэдтэй болох хандлага нэмэгдэж байна.

Боловсрол нь хүний хөгжилд ихээхэн нөлөөлдөг үзүүлэлт бөгөөд түүнийг нийгэм, эдийн засгийн олон хүчин зүйлтэй холбон судалгаанд өргөн хэрэглэдэг. Хүний амьдралын анхдагч орчин өрх, гэр бүлийн хувьд өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин нь өрхийн сайн сайхан байдал, ядуурал, хүүхдийн сургуульд хамрагдалт, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон хүчин зүйлд шууд нөлөөлдөг.


Өрх толгойлсон эцэг, эхийн боловсролын түвшин өмнөх тооллогын үеийнхээс сайжирчээ. Ерөнхий дүнгээрээ боловсролгүй эцэг, эхийн хувь 3.6 пунктээр буурч, 2.3 хувь болов. Мөн хүйсийн хувьд ч ойролцоо дүнгээр буурчээ. Боловсролгүй өрх толгойлсон эцгийн нийт өрх толгойлсон эцэгт эзлэх хувийн жин 2010 оны адил давамгай хэвээр байна. Боловсролын түвшнээр ангилахад бүрэн дунд боловсролтой өрх толгойлсон эцгийн хувь 6.0 пунктээр, дээд боловсролтой эхийнх 9.3 пунктээр нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 3.5. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХУВИАР, 2010, 2020 ОН

Боловсролын түвшин	2010			2020			Хүйсийн харьцаа	
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	2010	2020
БҮГД - Тоо	83 929	14 771	69 158	105 592	14 620	90 972	21.4	16.1
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	-	-
Боловсролгүй	6.0	6.3	5.9	2.3	2.6	2.3	22.9	18.2
Бага	15.0	18.9	14.2	9.0	10.8	8.7	28.5	19.8
Суурь	15.9	19.5	15.1	15.5	21.0	14.6	27.5	23.2
Бүрэн дунд	29.4	26.7	29.9	31.7	32.7	31.5	19.1	16.7
Техник болон мэргэжлийн	3.9	4.4	3.8	5.2	6.4	5.1	24.5	20.3
Тусгай мэргэжлийн дунд	11.1	7.9	11.8	9.0	7.0	9.3	14.3	12.1
Дээд	18.7	16.2	19.2	27.2	19.5	28.5	18.1	11.0

Боловсролтой өрх толгойлсон эцэг, эхийн хүйсийн харьцаа боловсролын аль ч түвшинд өмнөх тооллогын үеэс буурсан нь боловсрол дахь жендэрийн тэгш бус байдал улам нэмэгдсэнийг харуулна.

ЗУРАГ 3.17. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШНИЙ ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН



Дээд боловсролтой эцэг, эхийн хүйсийн харьцаа хамгийн ихээр буурсан байна.

ХҮСНЭГТ 3.6. ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд			Гэр			Байшин			Бусад		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
БҮГД - Тоо	105 592	14 620	90 972	40 024	5 852	34 172	64 432	8 637	55 795	1 136	131	1 005
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	89.7	92.2	89.3	92.7	94.5	92.3	88.1	90.8	87.7	74.6	79.4	74.0
Бусдын сууцанд түрээстэй суудаг	3.8	2.9	3.9	2.0	1.3	2.1	4.8	3.9	4.9	8.3	5.3	8.7
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	6.1	4.6	6.4	5.0	3.9	5.2	6.6	4.9	6.9	15.5	13.7	15.7
Бусад	0.4	0.3	0.4	0.3	0.2	0.3	0.4	0.3	0.5	1.6	1.5	1.6
ХОТ - Тоо	77 583	10 024	67 559	22 717	2 909	19 808	54 114	7 029	47 085	752	86	666
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	88.8	91.4	88.4	90.2	92.9	89.8	88.3	91.0	87.9	75.3	79.1	74.8
Бусдын сууцанд түрээстэй суудаг	4.5	3.6	4.6	3.1	2.2	3.2	5.0	4.2	5.1	8.4	7.0	8.6
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	6.3	4.6	6.5	6.2	4.7	6.5	6.2	4.5	6.5	14.1	11.6	14.4
Бусад	0.5	0.3	0.5	0.5	0.2	0.5	0.5	0.4	0.5	2.3	2.3	2.3
ХӨДӨӨ - Тоо	28 009	4 596	23 413	17 307	2 943	14 364	10 318	1 608	8 710	384	45	339
Хувь	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Өөрийн эзэмшлийн	92.3	93.8	92.0	95.8	96.1	95.8	87.0	90.0	86.5	73.4	80.0	72.6
Бусдын сууцанд түрээстэй суудаг	1.8	1.3	1.9	0.6	0.5	0.6	3.6	2.6	3.8	8.1	2.2	8.8
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	5.7	4.7	5.9	3.5	3.2	3.5	9.0	7.1	9.3	18.2	17.8	18.3
Бусад	0.2	0.2	0.2	0.1	0.1	0.1	0.4	0.2	0.4	0.3	0.0	0.3

Өөрийн эзэмшлийн сууцгүй эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эрэгтэй тэргүүлэгчтэй өрхтэй харьцуулахад их байсантай адилаар өрх толгойлсон эхчүүд бусдын сууцанд амьдрах явдал илүү байна. Улсын хэмжээнд

өөрийн эзэмшлийн сууцгүй 9.7 мянган өрх толгойлсон эх байгаа нь нийт өрх толгойлсон эхчүүдийн 10.7 хувь юм. Энэ үзүүлэлт өрх толгойлсон эцгүүдийн хувьд 7.8 хувь байна. Гэрт амьдардаг өрх толгойлсон эцэг, эхийн 92.0-оос дээш хувь өөрийн эзэмшлийн сууцтай бол байшинд энэ хувь 88.0-91.0 байна. Хотын өрх толгойлсон эцэг, эх хөдөөнийхнийг бодвол бусдын эзэмшлийн сууцанд ихээр амьдарч байна.

ДҮГНЭЛТ

- Манай улсын хүн амын өсөлтийн хувь 1980-аад оны үед оргил цэгтээ хүрч байжээ.
- Манай улсын хүн амын хүйсийн харьцаа 1944 болон 2010 оны үед хамгийн доод цэгтээ хүрч унасан байна. Энэ нь дэлхийн II дайн болон Монгол Улс зах зээлийн нийгэмд шилжсэний дараах үед эрэгтэйчүүдийн тоо нэлээд буурсныг харуулж байна.
- Хүн амын тоо өсөж байгаа хэдий ч хүйсийн харьцаа буурсаар байна.
- Хүн амын хүйсийн харьцаанаас харахад төрөх үед хөвгүүд давамгайлдаг бол нас ахих тутам эрэгтэйчүүдийн тоо буурч, хүйсийн харьцаа тасралтгүй буурдаг байна.
- Эрэгтэйчүүдийн нас баралт залуужиж байгаагийн дээр эмэгтэйчүүдийнхээс их байна.
- Манай улс дундаж наслалтын зөрүүгээр дэлхийн 185 орноос эхний 13-т орж байгаа тул эрэгтэйчүүдийн дундаж наслалт бага байгаа шалтгааныг судалж, онцгой анхаарах шаардлагатайг харуулна.
- Дундаж наслалтын зөрүү их байх нь 2013 оноос эхэлсэн бөгөөд энэ зөрүү буурахгүй хадгалагдсаар байна. Дундаж наслалтын зөрүү холдсоор байгаа нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал муу, нас баралт их байгаатай холбоотой юм.
- ХАОСТ-ын 2020 оны дүнг 2010 онтой харьцуулахад өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо огцом өсжээ.
- Ганц бие эрэгтэй, эмэгтэйчүүд нэмэгдсэн нь гэр бүл салалт их байгаатай холбоотой юм.
- Сүүлийн 10 жилийн хугацаанд өөрийн эзэмшлийн сууцтай өрхийн эзлэх хувь багагүй нэмэгдсэн байгаа нь улсаас авч хэрэгжүүлж байгаа “Дахин төлөвлөлт”, “Орон сууцжуулах хөтөлбөр, төсөл” зэргийн үр дүнд гарсан нааштай өөрчлөлт байж болох юм.
- Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх бусдын сууцанд амьдрах явдал бусадтай харьцуулахад өндөр байгаа бөгөөд тэдний орлогыг нэмэгдүүлэх, хүний анхдагч хэрэгцээ болсон хямд, чанартай сууцаар хангах, зээлийн хүүгийн бодлогоор дэмжихэд цаашид үргэлжлүүлэн анхаарах шаардлагатай байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮЛ МЭНД, ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

ЭРҮҮЛ МЭНД, 2020 оны эцэст

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид		2019	927 293
		2020	836 272



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

 	2019	45 232
	2020	33 376



Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)	2019	13
	2020	12
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох)	2019	16
	2020	14


ЭРҮҮЛ МЭНД, ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Хүн амын эрүүл мэндийн талаар ярилцахын өмнө тухайн улсын эрүүл мэндийн салбарын тогтолцоо, хүчин чадал, хүний нөөцийн асуудал зайлшгүй хөндөгдөх асуудлыг нэг юм.

Энэ бүлгийн эрүүл мэндтэй холбоотой хэсгийг албан ёсны болон захиргааны мэдээнд үндэслэн боловсруулав. Өөрөөр хэлбэл ҮСХ-ны хүн амын болон эрүүл мэндийн 2019 оны мэдээ, танилцуулгад үндэслэн гаргав. Харин хөгжлийн бэрхшээлтэй холбоотой хэсгийг 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын мэдээлэлд үндэслэн тооцлоо.

Монгол Улсын эрүүл мэндийн байгууллага 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 4459 болж, өмнөх оноос 105 байгууллага буюу 2.4 хувиар өссөн нь хувийн эмнэлэг, эмийн сан 169 буюу 5.2 хувиар өссөнтэй холбоотой байна.

ЗУРАГ 4.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОО, 2010-2019 ОН




Төрийн өмчийн эмнэлэг 2019 онд 400 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 3-аар нэмэгдсэн бол хувийн эмнэлэг 1681 болж, 10 жилийн дунджаас 402 буюу 31.5 хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 4.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР, 2019 ОН



Эрүүл мэндийн салбарт 2019 оны байдлаар нийт 54687 ажиллагчид ажиллаж байгаа бөгөөд тэдний 44807 буюу 81.9 хувь нь эмэгтэйчүүд байна.


ЗУРАГ 4.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ТОО, ХҮЙСЭЭР, 2010-2019 ОН



Дээрх зургаас харахад эрүүл мэндийн салбарт ажиллагчдын ихэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа байдалд ямар ч өөрчлөлт гарахгүй байсаар байна. 2010 онд тус салбарт ажиллагчдын 82.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол 2019 онд 81.9 болж бага зэрэг буурсан байна.


Манай улсын хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа ойролцоогоор 100 охинд 105 хөвгүүн байх хандлага хадгалагдсаар байна. Харин нас барах үеийн хүйсийн харьцаа жилээс жилд огцом өсөж байна. 2019 оны байдлаар нас барж байгаа 100 эмэгтэйд 161 эрэгтэй ногдох болсон нь анхаарахгүй байхын аргагүй мэдээлэл юм. Эндээс эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг онцгой анхаарах шаардлага харагдаж байна.

ЗУРАГ 4.4. ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР




Монгол Улсын хүн амын нас баралт 2019 онд 18.4 мянга болж, өмнөх оноос 539 буюу 3.0 хувиар өссөн бол төрөлт 79.6 мянга болж, 1136 буюу 1.4 хувиар өсжээ.

ЗУРАГ 4.5. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, 2010-2019 ОН



2019 онд Монгол Улсын хүн амын тоонд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 49.1, эмэгтэйчүүдийнх 50.9 байгаа бол нас баралтанд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 61.7, эмэгтэйчүүдийнх 38.3 хувь байна.

ЗУРАГ 4.6. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Өөрөөр хэлбэл нас барж буй 10 хүн тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй хүн байна.

Нас баралтын түвшин¹⁴ 30 жилийн өмнө буюу 1990 онд 8.4 байсан бол 10 жилийн дараа 6.6 болж буурсан байна. Энэ үзүүлэлт 2019 онд 5.4 болсон нь сүүлийн 10 жилийн дунджаас 0.3 пунктээр буурчээ.


ЗУРАГ 4.7. НИЙТ НАС БАРАЛТ, 1000 ХҮНД НОГДОХ ТҮВШИН, СОНГОСОН ОНООР



Хүн амын нас баралтын түвшинг хүйсээр харвал аль ч хүйсийн хувьд буурсан хэдий ч эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин эмэгтэйчүүдийнхээс 2.6 пунктээр их байна.


14 Тухайн жилийн 1000 хүнд тутамд ногдох нас баралтын тоо. "Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал", УСХ, 2013 он

ЗУРАГ 4.8. ХҮН АМЫН НАС БАРАЛТ, 1000 ХҮНД НОГДОХ ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2010-2019 ОН




Хүн амын нас баралтын хүйсийн харьцаа 2019 онд 100 эмэгтэй 157 болж, 2010 оноос 8 пунктээр нэмэгджээ. Насны бүлгээр харвал 65-аас дээш наснаас бусад насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байна. Нас баралтын хүйсийн харьцаа 20-64 насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2-3 дахин их байна. 0-19 насны хүүхдийн хүйсийн харьцаа 2019 онд дунджаар 161 болж, 2010 оноос 1.3 дахин буурсан байна.

ЗУРАГ 4.9. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2019 ОН



Нас баралтын түвшинг хүйсээр харвал бүх аймагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.4-3.0 пунктээр илүү байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн нас баралтын түвшин харьцангуй өндөр байна.

ЗУРАГ 4.10. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2019 ОН



Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1990 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

Нас баралтын түвшин 2019 оны байдлаар бүх өвчний төрөлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байгаа бөгөөд гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг болон амьсгалын тогтолцооны өвчнөөр эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин эмэгтэйчүүдийнхээс 2-4 дахин их байна.


ХҮСНЭГТ 4.1. НАС БАРАЛТЫН ТҮВШИН (10000 ХҮНД НОГДОХ), ЗОНХИЛОХ ӨВЧНИЙ ТӨРӨЛ, ХҮЙС, НАСНЫ БҮЛЭГ, БАЙРШЛААР, 2019 ОН

Үзүүлэлт	Нийт нас баралт	Зүрх, судасны тогтолцооны өвчин	Хавдар	Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин
ХҮЙС						
Эрэгтэй	66.8	20.8	16.2	14.4	4.2	3.4
Эмэгтэй	41.4	13.9	12.6	3.4	3.2	1.7
НАСНЫ БҮЛЭГ						
20 хүртэлх	12.9	0.3	0.5	2.5	0.2	1.5
20-44	21.6	3.6	2.4	10.7	1.7	0.8
45-64	111.2	35.5	36.3	18.2	9.0	3.8
65, түүнээс дээш	485.8	224.1	159.2	9.4	30.6	22.3
БАЙРШИЛ						
Хот	56.4	15.5	14.2	11.0	4.3	2.7
Хөдөө	51.9	18.9	14.5	7.0	3.1	2.3

Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2.8 мянган гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын тохиолдол бүртгэгдэж, үүний 80.0 гаруй хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.


Гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 10000 хүнд ногдох түвшинг хүйсээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 4.2 дахин их байна. Энэ төрлийн нас баралтын 10000 хүнд ногдох эрэгтэйчүүдийн түвшин 2019 онд 14, эмэгтэйчүүдийнх 3 болж буурсан байна.

ЗУРАГ 4.11. ГЭМТЭЛ, ХОРДЛОГО БА ГАДНЫ ШАЛТГААНТ БУСАД ЭМГЭГЭЭР НАС БАРАЛТ, 10000 ХҮНД НОГДОХООР, ХҮЙСЭЭР, 2019 ОН



Гэмтэл хордлого, гадны шалтгаант бусад эмгэгээр нас баралтыг хэлбэрээр, сүүлийн 10 жилийн дунджаар харвал ямар нэг хорт бодист санамсаргүй өртөж нас барсан тохиолдол 23.1 хувь, зам тээврийн осолд өртөж нас барсан тохиолдол 19.9 хувь, амиа хорлож нас барсан тохиолдол 16.6 хувь, байгалийн хүчинд өртөн нас барсан тохиолдол 7.1 хувь, ямар нэг зүйлээс унаж нас барсан тохиолдол 6.7 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 4.12. ГЭМТЭЛ, ХОРДЛОГО БА ГАДНЫ ШАЛТГААНТ БУСАД ЭМГЭГЭЭР НАС БАРАЛТ, ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Спиртэд санамсаргүй хордож нас барсан тохиолдол 2019 онд 669 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 107 тохиолдол буюу 16.0 хувиар өсөж, өмнөх оноос 66 буюу 9.0 хувиар буурсан байна.


Сүүлийн 10 жилийн дунджаар спиртэд санамсаргүй хордож нас барсан тохиолдлын 83.6 хувь нь эрэгтэйчүүд байна.

ЗУРАГ 4.13. СПИРТЭД САНАМСАРГҮЙ ХОРДОЖ НАС БАРСАН ТОХИОЛДЛЫН ТҮВШИН 10000 ХҮНД НОГДОХООР, ХҮЙСЭЭР, 2010-2019 ОН



Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харвал 40-64 насанд хамгийн их буюу дунджаар 5.9 байна. Хүйсээр харвал 2019 онд 0-4 насны эмэгтэй хүүхэд спиртэд хордож нас барсан тохиолдол гарсан байна. 5-19 насанд тохиолдол гараагүй, бусад насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 0.2-9.2 пунктээр их байна.

ЗУРАГ 4.16. ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛООР НАС БАРАЛТЫН ТҮВШИНГ, 10000 ХҮНД НОГДОХООР, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2019 ОН




Зам, тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшинг насны бүлгээр харвал 25-аас дээш насанд дунджаар 2.6 болж, улсын дунджаас 1.5 дахин их байна. Харин хүйсээр авч үзвэл бүх насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 0.1-4.5 пунктээр их байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салшгүй нэг хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний аж байдлын талаарх мэдээлэл юм.

Монгол Улсын 2020 оны ХАОСТ-ын дүнгээр улсын хэмжээнд 106.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 3.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 58.9 мянга буюу 55.4 хувь нь эрэгтэй, 47.4 мянга буюу 44.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 4.17. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН




Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 46.2 хувь, эмэгтэйчүүдийн 45.3 хувийг 45-64 насныхан эзэлж байгаа нь хамгийн их байна. Харин 65, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.8 дахин их байгаа нь эмэгтэйчүүд өндөр насалдагтай холбоотой юм.

Тооллогоор нийт 50.6 мянган төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа бөгөөд өмнөх тооллогоос 37.7 хувиар өссөн байна. Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн 55.7 мянга байгаа нь өмнөх тооллогоос 21.8 хувиар буурчээ.


Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэйчүүдийн 45.0 хувь нь төрөлхийн, 55.0 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байгаа бол эмэгтэйчүүдийн 50.8 хувь нь төрөлхийн, 49.2 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

ЗУРАГ 4.18. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН, БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ, ХҮЙС, ХУВИАР, 2010, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоогоор Хөвсгөл, Увс, Сэлэнгэ, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул аймгууд тэргүүлж байна.


ЗУРАГ 4.19. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийн хэлбэрээр нь харвал 36.1 мянга буюу 33.9 хувийг бусад¹⁵ хэлбэрийн бэрхшээлтэй хүмүүс эзэлж байгаа нь хамгийн их байна. Үүний дараа 24.0 мянга буюу 22.5 хувийг хөдөлгөөний бэрхшээлтэй, 21.5 мянга 20.2 хувийг сэтгэцийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Харин хамгийн бага хувийг харааны бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад сэтгэцийн бэрхшээлтэй хүн ам 3.0 хувиар өсжээ.

15 Хавсарсан болон бусад хөгжлийн бэрхшээлийг оруулав.

ЗУРАГ 4.20. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН




ДҮГНЭЛТ

- Эрүүл мэндийн салбарт ажиллагчдын ихэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа байдалд ямар ч өөрчлөлт гарахгүй байсаар байна.
- Хүн амын нас барах үеийн хүйсийн харьцаа жилээс жилд огцом өсөж байгааг анхаарахгүй байхын аргагүй юм. Тиймээс эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг онцгой анхаарах шаардлага бий болсон байна.
- Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1990 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоогоор Хөвсгөл, Увс, Сэлэнгэ, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул аймгууд тэргүүлж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК, 2020/2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭХЭНД



БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ, СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ

Энэ бүлгийг Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүн болон боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистик мэдээлэлд үндэслэн боловсруулав.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.7 хувь байгаа нь 2010 оныхоос 0.4 пунктээр өссөний дотор эрэгтэйчүүдийнх мөн 0.4 пунктээр, эмэгтэйчүүдийнх 0.6 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 5.1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН

Бичиг үсгийн мэдлэг	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бичиг үсэг мэддэг	98.3	98.2	98.3	98.7	98.7	98.9
Бичиг үсэг мэддэггүй	1.7	1.8	1.7	1.3	1.3	1.1


Бичиг үсэг эзэмшсэн хүн амыг хот, хөдөөгөөр харьцуулж харахад 15, түүнээс дээш насанд хотын хүн амын 99.3 хувь нь бичиг үсэг мэддэг бөгөөд хүйсээр харахад ойролцоо байна. Харин хөдөөгийн хүн амын 97.6 хувь нь бичиг үсэг мэдэж байгаа бол 2.4 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна. Үүнийг мөн хүйсээр харахад ойролцоо дүнтэй байгааг дараах хүснэгтээр харж болно.

ХҮСНЭГТ 5.2. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2020 ОН

Байршил	Бичиг үсэг мэддэг			Бичиг үсэг мэддэггүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	98.7	98.6	98.9	1.3	1.4	1.1
Хот	99.3	99.2	99.4	0.7	0.8	0.6
Хөдөө	97.6	97.3	97.9	2.4	2.7	2.1

Монгол Улсын 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэг 1921 онд 2.1 хувь байсан бол 1944 онд 27.3 хувь, 1956 онд 70.5 хувь болж огцом өсөж, 1979 онд 92.7 хувь, 2010 онд 98.3 хувь, 2020 онд 98.7 хувь болж өсжээ.

ЗУРАГ 5.1. ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХУВИАР, СОНГОСОН ОНООР



Бичиг үсэг мэддэг болон мэддэггүй б, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувийг бүс, аймаг, нийслэлээр Хүснэгт 5.3-д харууллаа. Эндээс харахад б, түүнээс дээш насны хүн амд бичиг үсэг мэддэггүй хүний эзлэх хувь аймаг болгонд өөр байхын зэрэгцээ хүйсээр харахад Баян-Өлгий, Булган, Ховд аймаг болон Улаанбаатар хотод бичиг үсэг мэддэггүй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ их байна. Бусад аймагт бичиг үсэг мэддэггүй 100 эмэгтэйд 5-90 эрэгтэй илүү ногдож байна. Харин бичиг үсэг мэддэг хүн амын хүйсийн харьцааг харахад бүх


аймагт бичиг үсэг мэддэг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ их байна.

ХҮСНЭГТ 5.3. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХҮЙС, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Бичиг үсэг мэддэг			Хүйсийн харьцаа	Бичиг үсэг мэддэггүй			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	98.2	98.0	98.3	91.6	1.8	2.0	1.7	109.7
БАРУУН БҮС	97.4	97.3	97.5	97.5	2.6	2.7	2.5	105.9
Баян-Өлгий	97.3	97.5	97.2	99.6	2.7	2.5	2.8	88.8
Говь-Алтай	97.9	97.8	98.0	92.4	2.1	2.2	2.0	105.3
Завхан	97.3	97.1	97.5	96.0	2.7	2.9	2.5	111.1
Увс	97.0	96.3	97.6	98.5	3.0	3.7	2.4	154.0
Ховд	97.6	97.8	97.4	99.2	2.4	2.2	2.6	84.0
ХАНГАЙН БҮС	97.9	97.6	98.1	93.9	2.1	2.4	1.9	116.3
Архангай	97.8	97.5	98.1	95.1	2.2	2.5	1.9	125.6
Баянхонгор	97.6	97.5	97.8	94.4	2.4	2.5	2.2	108.3
Булган	98.4	98.5	98.3	96.1	1.6	1.5	1.7	84.6
Орхон	99.0	98.8	99.2	89.6	1.0	1.2	0.8	142.1
Өвөрхангай	97.1	96.9	97.3	93.8	2.9	3.1	2.7	107.3
Хөвсгөл	97.5	97.1	97.9	95.2	2.5	2.9	2.1	130.7
ТӨВИЙН БҮС	98.2	97.9	98.5	91.8	1.8	2.1	1.5	124.8
Говьсүмбэр	98.2	97.5	98.8	88.0	1.8	2.5	1.2	190.9
Дархан-Уул	98.8	98.6	99.0	88.8	1.2	1.4	1.0	124.0
Дорноговь	97.6	97.1	98.0	90.3	2.4	2.9	2.0	135.3
Дундговь	97.6	97.2	97.9	90.4	2.4	2.8	2.1	123.1
Өмнөговь	98.7	98.5	98.8	87.8	1.3	1.5	1.2	109.1
Сэлэнгэ	98.3	97.9	98.6	94.7	1.7	2.1	1.4	136.5
Төв	97.9	97.8	98.0	97.7	2.1	2.2	2.0	109.4
ЗҮҮН БҮС	96.9	96.6	97.1	95.4	3.1	3.4	2.9	112.4
Дорнод	97.7	97.5	97.9	95.4	2.3	2.5	2.1	115.6
Сүхбаатар	96.0	95.8	96.2	97.3	4.0	4.2	3.8	108.8
Хэнтий	96.6	96.3	96.9	94.0	3.4	3.7	3.1	113.4
УЛААНБААТАР	98.7	98.7	98.8	88.5	1.3	1.3	1.2	99.3

Үндэсний статистикийн хорооноос гаргасан албан ёсны статистикийн мэдээллээр Монгол Улсын хэмжээнд 2019/2020 оны хичээлийн жилд нийт 1439¹⁶ цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, сургуулийн өмнөх байгууллагад нийт 263.3 мянган хүүхэд хамрагдсан байна. Эдгээр үзүүлэлтийг 2010/2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад 2019/2020 оны хичээлийн жилд цэцэрлэгийн тоо 600 буюу 71.5 хувиар, СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 106.2 мянга буюу 67.5 хувиар өсжээ.

ЗУРАГ 5.2. ЦЭЦЭРЛЭГ, СӨБ-Д ХАМРАГДСАН ХҮҮХЭД, СОНГОСОН ОНООР



Харин 2020 оны ХАОСТ-ын дүнгээр 2-5 насны нийт 312.1 мянган хүүхэд байгаагаас 262.5 буюу 84.1 хувь нь цэцэрлэгт хамрагдаж, 15.9 хувь нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна. Өмнөх тооллогын үетэй харьцуулахад цэцэрлэгийн тоо 1.7 дахин нэмэгдсэн ч цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоо 2.2 дахин өсжээ. Эндээс 2-5 настай нийт хүүхдийн 60.1 (2010 онд) хувь нь цэцэрлэгт хамрагдаж байсан бол 2020 онд 84.1 хувь болж цэцэрлэгт хамрагдалт 24.0 пунктээр нэмэгджээ. Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн 51.1 хувь нь хөвгүүд, 48.9 хувь нь охид байна. Энэ үзүүлэлтийг 2010 онтой харьцуулахад хөвгүүд (50.1 хувь нь хөвгүүд)-ийн цэцэрлэгт хамрагдах байдал нэмэгдсэн байна.


ХҮСНЭГТ 5.4. ХОЁРООС ТАВАН НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДДАГ ЭСЭХ, НАС, ХҮЙСЭЭР, 2020 ОН

Нас	Цэцэрлэгт хамрагддаг			Хүйсийн харьцаа	Цэцэрлэгт хамрагддаггүй			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	262 531	134 043	128 488	104.3	49 621	26 278	23 343	112.6
2	48 450	24 799	23 651	104.9	25 911	13 619	12 292	110.8
3	66 014	33 602	32 412	103.7	11 627	6 209	5 418	114.6
4	72 394	36 874	35 520	103.8	7 244	3 897	3 347	116.4
5	75 673	38 768	36 905	105.0	4 839	2 553	2 286	111.7

Цэцэрлэгт хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцааг харвал 100 охин тутамд 113 хөвгүүн ногдож байна. Бүх насанд хөвгүүдийн тоо охидоос илүү байна.

Цэцэрлэгт хамрагдахгүй байгаа хүүхдүүдийг 2010 онтой харьцуулахад 2020 онд хөвгүүд 24.5 пунктээр охид 23.5 пунктээр тус тус буурчээ.

ЗУРАГ 5.3. ХОЁРООС ТАВАН НАСНЫ ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР, ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДДАГ ЭСЭХ, ХУВИАР, 2010, 2020 ОН



Сургуулийн өмнөх боловсрол(СӨБ)-д хамрагдсан хүүхдийн хүйсийн харьцааг хот, хөдөөгөөр явч үзэхэд хот, хөдөөд ялгаагүй хөвгүүдийн тоо олон байна. Энэ нь бага насанд эрэгтэйчүүд давамгайлж байдагтай холбоотой байна.

ХҮСНЭГТ 5.5. ЦЭЦЭРЛЭГТ ХАМРАГДДАГ 2-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Нас	Цэцэрлэгт хамрагддаг			Хүйсийн харьцаа	Хувь - А			Хувь - Б		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	262 531	134 043	128 488	104.3	100.0	51.1	48.9	100.0	100.0	100.0
2	48 450	24 799	23 651	104.9	100.0	51.2	48.8	18.5	18.5	18.4
3	66 014	33 602	32 412	103.7	100.0	50.9	49.1	25.1	25.1	25.2
4	72 394	36 874	35 520	103.8	100.0	50.9	49.1	27.6	27.5	27.6
5	75 673	38 768	36 905	105.0	100.0	51.2	48.8	28.8	28.9	28.7
ХОТ	183 660	93 882	89 778	104.6	100.0	51.1	48.9	100.0	100.0	100.0
2	33 366	17 098	16 268	105.1	100.0	51.2	48.8	18.2	18.2	18.1
3	46 305	23 599	22 706	103.9	100.0	51.0	49.0	25.2	25.1	25.3
4	50 821	25 958	24 863	104.4	100.0	51.1	48.9	27.7	27.6	27.7
5	53 168	27 227	25 941	105.0	100.0	51.2	48.8	28.9	29.0	28.9
ХӨДӨӨ	78 871	40 161	38 710	103.7	100.0	50.9	49.1	100.0	100.0	100.0
2	15 084	7 701	7 383	104.3	100.0	51.1	48.9	19.1	19.2	19.1
3	19 709	10 003	9 706	103.1	100.0	50.8	49.2	25.0	24.9	25.1
4	21 573	10 916	10 657	102.4	100.0	50.6	49.4	27.4	27.2	27.5
5	22 505	11 541	10 964	105.3	100.0	51.3	48.7	28.5	28.7	28.3

2020 оны тооллогоор 6-29 насны 1256.6¹⁷ мянган хүн байгаагаас 72.6 хувь нь ямар нэгэн шатны сургуульд суралцаж байгааг өмнө дурдсан. Ялангуяа 6-17 насны буюу ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн 98.0 хувь нь сургуульд хамрагдаж байна.

Сургуульд суралцаж байгаа хүн амыг хүйсээр харахад хүйсийн хувьд бараг ялгаагүй буюу 49.9 хувь нь эрэгтэйчүүд, 50.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Суралцагчдын хүйсийн харьцааг насаар харахад бүх насны бүлэгт суралцаж байгаа хүүхдүүдийн хувьд эрэгтэйчүүд давамгайлж байна. 2010 онд 15 наснаас эхлэн охид давамгайлж байсан бол 2020 онд хөвгүүд давамгайлсаар байна.


ХҮСНЭГТ 5.6. СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ 6-15 НАСНЫ ХҮҮХЭД, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

Нас	Улсын дүн			Хүйсийн харьцаа	Хот		Хүйсийн харьцаа	Хөдөө		Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	590 667	300 910	289 757	103.8	202 455	194 668	104.0	98 455	95 089	103.5
6	73 659	37 678	35 981	104.7	26 486	25 295	104.7	11 192	10 686	104.7
7	71 761	36 361	35 400	102.7	25 651	25 018	102.5	10 710	10 382	103.2
8	69 193	35 459	33 734	105.1	24 467	23 320	104.9	10 992	10 414	105.6
9	62 763	31 972	30 791	103.8	21 743	20 805	104.5	10 229	9 986	102.4
10-14	271 770	138 493	133 277	103.9	90 983	87 480	104.0	47 510	45 797	103.7
15	41 521	20 947	20 574	101.8	13 125	12 750	102.9	7 822	7 824	100.0

Сургуульд хамрагдалтыг өмнөх тооллогуудын дүнтэй харьцуулахад тогтмол өсжээ. 2020 оны тооллогоор 6-29 насны хүн амын 72.6 хувь нь сургуульд хамрагдаж байгаа бөгөөд 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 14.5 пунктээр нэмэгдсэн байна. Ялангуяа 6-17 насны буюу ЕБС-ийн насны хүүхдийн 98.0 хувь нь сургуульд хамрагдаж байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтыг судлахад энэ насны хүн амын тал хүрэхгүй (47.8 хувь) хувь, 2010 оны тооллогоор 56.9 хувь нь сургуульд суралцаж байсан бол 2020 онд 72.6 хувь болж нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5.4. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХУВИАР, 2000, 2010, 2020 ОН



Дээрх үзүүлэлтийг хүйсээр ангилахад эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын хувь эрэгтэйчүүдийнхээс 2.2 пунктээр бага байна. Энэ нь 2010 онд 5.1 пункт байснаас харахад эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт сайжирч байгаа нь харагдаж байна (Хүснэгт 5.8). Эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын хувь 2 тооллогын хооронд 14.4 пунктээр, эрэгтэйчүүдийнх 17.2 пунктээр өсжээ.

Сургуульд хамрагдалтад гарсан томоохон өөрчлөлт бол сургуульд хамрагдагчдын хувьд хүйс болон хот, хөдөөгөөр ялгаварлахгүй бүх ангилалд нэлээд нэмэгджээ. Тухайлбал, хөдөөгийн хүн амын сургуульд хамрагдалт өмнөх тооллогоос 18.4 пунктээр, тэр дундаа эрэгтэйчүүдийнх 18.8 пункт, эмэгтэйчүүдийнх 17.8 пунктээр нэмэгдсэн явдал юм.

ХҮСНЭГТ 5.7. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАС, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2010, 2020 ОН

Нас	Улсын дүн			Хүйсийн ялгаа*	Хот			Хүйсийн ялгаа*	Хөдөө			Хүйсийн ялгаа*
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД-2010 он	56.9	54.4	59.4	5.1	58.9	57.1	60.7	3.5	52.2	48.6	56.3	7.7
7	97.9	97.7	98.1	0.4	98.4	98.3	98.5	0.2	97.0	96.7	97.4	0.7
8	98.4	98.3	98.6	0.3	98.7	98.6	98.7	0.1	98.0	97.8	98.3	0.5
9	98.5	98.3	98.6	0.3	98.7	98.6	98.9	0.2	98.0	97.8	98.2	0.5
10	98.2	97.9	98.5	0.7	98.5	98.3	98.7	0.4	97.8	97.3	98.3	1.0
11	97.6	97.1	98.1	1.0	98.1	97.9	98.4	0.4	96.7	95.8	97.7	1.9
12	96.7	95.8	97.7	1.9	97.6	97.2	98.0	0.9	95.4	93.8	97.1	3.3
13	95.8	94.6	97.0	2.4	97.1	96.5	97.6	1.1	93.9	91.9	96.0	4.1
14	94.7	92.8	96.7	3.8	96.6	95.8	97.4	1.7	91.9	88.4	95.5	7.0
15	93.0	90.5	95.6	5.1	95.8	94.7	96.9	2.3	88.2	83.5	93.1	9.7
16-19	75.9	69.6	82.5	12.9	82.9	78.9	86.8	7.9	54.4	45.2	66.8	21.6
20-24	29.8	25.8	33.8	8.0	37.3	33.5	40.9	7.4	6.2	5.1	7.6	2.4
25-29	5.6	4.7	6.5	1.8	7.2	6.1	8.3	2.2	2.0	1.8	2.2	0.4
БҮГД-2020 он	72.6	71.5	73.8	2.2	73.7	73.8	73.6	-0.2	70.6	67.4	74.1	6.7
6	93.3	93.0	93.6	0.6	93.0	92.8	93.2	0.3	94.0	93.4	94.5	1.1
7	97.3	96.9	97.7	0.8	97.6	97.3	97.9	0.6	96.7	96.0	97.3	1.2
8	98.9	98.9	98.9	0.0	98.7	98.7	98.7	0.1	99.2	99.2	99.2	-0.1
9	98.8	98.7	98.9	0.1	98.5	98.4	98.6	0.1	99.4	99.3	99.4	0.1
10	99.4	99.4	99.4	0.0	99.3	99.3	99.2	-0.1	99.6	99.5	99.6	0.2
11	99.4	99.3	99.5	0.1	99.3	99.3	99.4	0.1	99.5	99.4	99.6	0.3
12	99.4	99.3	99.5	0.1	99.4	99.3	99.4	0.0	99.5	99.3	99.6	0.3
13	99.3	99.2	99.5	0.2	99.4	99.4	99.3	0.0	99.3	99.0	99.7	0.6
14	99.2	99.0	99.4	0.5	99.3	99.1	99.4	0.3	99.1	98.8	99.5	0.7
15	98.3	97.6	99.0	1.5	98.8	98.5	99.0	0.5	97.5	96.0	99.0	3.0
16-19	90.1	86.8	93.6	6.9	92.3	90.4	94.3	3.9	86.7	81.1	92.5	11.5
20-24	53.4	50.2	56.7	6.6	56.7	55.5	57.9	2.4	48.3	42.4	54.9	12.5
25-29	17.9	17.0	18.9	1.9	20.2	19.7	20.7	1.0	12.8	11.4	14.4	3.0

Тайлбар: * эмэгтэй-эрэгтэй

Харин насаар ангилж үзвэл нэлээд сонирхолтой дүр зураг харагдаж байна. Өөрөөр хэлбэл хөдөөгийн 16-24 насны хүн амын сургуульд хамрагдалт өмнөх тооллогоос огцом өсөж, эрэгтэй, эмэгтэй хүн амын хувьд 25.8-47.3 пунктээр нэмэгдсэн бол хотынхны хувьд зөвхөн 20-24 насны эмэгтэйчүүд 22.0 пунктээр нэмэгджээ. Эндээс харахад хөдөөгийн залуучууд хот, суурин газарт шилжин сурч, боловсрохыг илүүд үздэг болжээ.

Боловсролын салбарт шинэчлэл хийж, 12 жилийн боловсрол эзэмшүүлэх болсонтой холбоотойгоор 2006 онд Ерөнхий боловсролын сургууль(ЕБС)-ийн 1 дүгээр ангид элсэх нас 6 болсон. Мөн 2010 оны тооллогоор 6 насны 42.1 мянган хүүхэд тоологдсоны 93.6 хувь, түүний дотор хөвгүүдийн 93.0 хувь, охидын 94.3 хувь нь сургуульд хамрагдсан байна. Харин 2020 оны тооллогоор улсын хэмжээнд 6 настны сургуульд хамрагдалт 93.3 хувь, хөвгүүдийнх 93.0 хувь, охидынх 93.6 байна. Эндээс харахад 10 жилийн хугацаанд онцын өөрчлөлт гараагүй байна. Харин охидын сургуульд хамрагдалт хөвгүүдийнхээс байнга өндөр байна.


Сургуульд суралцаж буй хүн амын хүйсийн ялгаа 15 наснаас эхлэн насны бүлэг нэмэгдэх тутам ихсэж байгаа бөгөөд 16-19 насанд хүйсийн ялгаа хамгийн их байна. Нас ахих тутам сургуульд хамрагдалт буурч байгаа энэ хандлага эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү ажиглагдаж байна.

Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуульд “Бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн

дунд боловсролыг 12 жилд тус тус эзэмшүүлнэ” гэж заасны дагуу сургуульд хамрагдалтыг бага, суурь боловсролын түвшнээр авч, өмнөх оны тооллогын дүнтэй харьцууллаа.

Сургуульд суралцаж байгаа 6-11 насны хүүхдийн 51.1 нь хөвгүүд, 48.9 хувь нь охид байна. Доорх зургаас харахад бага сургуульд суралцаж байгаа хүүхдүүд Монгол Улсад оршин суугаа Монгол Улсын харьяат 6-11 насны хүн амын 97.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллогын дүн (85.7)-гээс 12 пунктээр нэмэгдсэн сайн үзүүлэлт байлаа.


ЗУРАГ 5.5. ЗУРГААГААС АРВАН НЭГЭН НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2020 ОН



Улсын хэмжээнд 6-11 насны хөвгүүдийн бага сургуульд хамрагдалтын хувь охидынхоос 0.3 пунктээр, хотод 0.2 пунктээр, харин хөдөөд 0.5 пунктээр доогуур байна. Харин 2010 онд улсын хэмжээнд болон хотод хөвгүүдийн сургуульд хамрагдалт охидынхоос дээгүүр байжээ.

Бага сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн сургуульд хамрагдалт нас бүрт 90-ээс дээш хувьтай байна (Зураг 5.6). Сургуульд хамрагдаж буй охид, хөвгүүдийн тоо 6 наснаас эхлэн тасралтгүй буурч, 10 насанд өсөж, 11 настай хүүхдийн тоо дахин буурсан байна. Харин нас тус бүрт сургуульд хамрагдаж буй хувь тасралтгүй өссөн байна.

ЗУРАГ 5.6. ЗУРГААГААС АРВАН НЭГЭН НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН




Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор суурь боловсролд хамрагдаж байгаа 186.5 мянган хүүхэд байгаа бөгөөд хүйсийн харьцаа 103.8 байна.

Боловсролын шатлал ахихад сургуульд хамрагдаж байгаа хөвгүүдийн тоо цөөрч, охид давамгайлах


хандлагатай болж байна. Энэ харьцаа хот, хөдөөд харилцан адилгүй байна. Зураг 5.7-оос харахад суурь боловсролд хамрагдагчид хөдөөд хүйсийн хувьд илүү ялгаатай харагдаж байна. Тухайлбал, хөдөөгийн хөвгүүдийн сургуульд хамрагдалт охидоосоо 1.2 пунктээр бага байна.

ЗУРАГ 5.7. АРВАН ХОЁРООС АРВАН ТАВАН НАСНЫ ХҮҮХДИЙН СУУРЬ БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, ХҮЙС, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХУВИАР, 2020 ОН




Сургуульд хамрагдсан хүн амыг хүйсээр харвал насны бүлэг тус бүрт сургуульд хамрагдсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс их байгаа ч зөрүү бага байна. Харин 20-24 насанд сургуульд сурч байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 6.5 пунктээр илүү байна. Эндээс дээд боловсрол эзэмшихээр суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгааг дахин харуулж байна.

ЗУРАГ 5.8. ЗУРГААГААС ХОРИН ЕСӨН НАСНЫ ХҮН АМЫН СУРГУУЛЬД ХАМРАГДАЛТ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН



ҮСХ-ны албан ёсны мэдээгээр 2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 820 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнд 646.8 мянган хүүхэд суралцаж, өмнөх хичээлийн жилээс 119.7 мянгаар өссөн байна. Эдгээрээс 97.0 мянга нь ахлах ангид суралцжээ. Ахлах ангийн сурагчдын 45.3 хувь нь хөвгүүд 54.7 хувь нь охид байна.


ЗУРАГ 5.9. ЕБС-ИЙН ӨДРӨӨР СУРАЛЦАГЧИД, АНГИ, ХҮЙСЭЭР, 2019/2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД



Дээрх зургаас харахад ЕБС-ийн бага ангид суралцаж байгаа эрэгтэй хүүхдийн тоо их байсан бол дунд, ахлах ангид эмэгтэй хүүхдийн тоо их байгааг харж болно.


Монгол Улсын хэмжээнд 2019/2020 оны хичээлийн жилд нийт 80 техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээрт нийт 37.8 мянган суралцагч хамрагджээ. Суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2010/2011 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 25.6 мянга (55.5 хувь) нь эрэгтэй байсан бол энэ үзүүлэлт 2019/2020 оны хичээлийн жилд 22.3 мянга (58.9 хувь) болсон байна.

ЗУРАГ 5.10. ТБМБСБ-Д СУРАЛЦАГЧДЫН ТОО, ХҮЙСЭЭР, 2010-2020 ОН




Техникийн болон мэргэжлийн боловсролд суралцаж буй суралцагчдыг сонгон суралцаж буй салбар болон хүйсээр харвал уул уурхай, тээвэр, барилга, хөдөө аж ахуйн салбарт суралцагчдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа бол эрүүл мэнд, үйлчилгээ болон мэргэжлийн бусад салбарт суралцагчдын дийлэнхийг эмэгтэйчүүд эзэлж байна.

ЗУРАГ 5.11. ТБМБСБ-Д СУРАЛЦАГЧИД, СУРАЛЦАЖ БУЙ САЛБАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019/2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД




Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчдийг хүйсээр харвал мөн л эрэгтэйчүүд давамгайлж байна. Доорх зургаас харахад 2011-2013 оны хооронд хамгийн олон хүн суралцаж төгссөн бөгөөд хүйсийн харьцаа нэлээд ойролцоо байсан нь харагдаж байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд төгсөгчдийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ төгсөгчдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь ихсэж 60.0-аас дээш хувь болжээ.

ЗУРАГ 5.12. ТБМБСБ-ЫН НИЙТ ТӨГСӨГЧДИЙН ТОО, ХҮЙСЭЭР, 2010-2020 ОН




Түүнчлэн их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй эмэгтэй суралцагчдын эзлэх хувийг харвал бакалавраас дээш зэрэгт суралцагчдын 55.0-аас дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад суралцагчдын 47.0 хүртэлх хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Эндээс эмэгтэйчүүд мэргэжилтэй ажилтан болохын оронд дээд боловсрол эзэмшихийг илүүд үзэж байгаа нь харагдаж байна.

ЗУРАГ 5.13. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ БОЛОН ТБМБСБ-Д СУРАЛЦАЖ БУЙ ЭМЭГТЭЙ СУРАЛЦАГЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ЗЭРГЭЭР, 2002-2019 ОН



Манай улсад 2019/2020 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй нийт 95 их, дээд сургууль, коллеж байгаа бөгөөд тэдгээрт нийт 148.4 мянган оюутан суралцаж байна. Нийт суралцагчдын 90.6 мянга буюу 61.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 5.14. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧИД, ХҮЙСЭЭР, 2010-2019 ОН



Их, дээд сургуульд суралцаж буй оюутнуудыг суралцаж буй мэргэжлийн ерөнхий чиглэл болон хүйсээр харахад дараах байдалтай байна. Тухайлбал, боловсрол, анагаах, хүмүүнлэг болон нийгмийн салбарын мэргэжилтэн болохоор суралцагчдын дийлэнх буюу 62.8-83.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ хандлага 2010 оноос хойш өнөөг хүртэл өөрчлөгдсөнгүй хадгалагдсаар иржээ.


ЗУРАГ 5.15. ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧИД, МЭРГЭЖЛИЙН ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛЭЭР, ХҮЙСЭЭР, 2010, 2019 ОН



Түүнчлэн техник, технологийн болон үйлчилгээний салбарт суралцагчдын дийлэнхийг эрэгтэйчүүд эзэлж буй хандлага мөн хадгалагдаж байна. Харин 2010 онд байгалийн ухааны салбарт суралцагчдын 60.0-аас дээш хувийг эрэгтэйчүүд эзэлж байсан бол 2020 оны байдлаар 45.0 хүрэхгүй хувийг эрэгтэйчүүд эзлэх болжээ. Мөн хөдөө аж ахуйн салбарт суралцагчдын ихэнхийг эрэгтэйчүүдийн эзлэх болсон байна.

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага (ТБМБСБ) болон их, дээд сургууль (ИДС)-д суралцагчдын хүйсийн харьцааг тооцож үзвэл мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эмэгтэй тутамд ногдож буй эрэгтэй суралцагчдын тоо 2019/2020 оны хичээлийн жилд 143 болсон байна. Мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцагчдын хүйсийн харьцааг 2010 оноос хойш харвал, энэ салбарт суралцагчдын дунд эрэгтэйчүүд байнга давамгайлсаар иржээ. Харин ИДС-д суралцагчдын хүйсийн харьцаа эсрэг дүр зурагтай харагдаж байна. Доорх зургаас харахад 2019/2020 хичээлийн жилд ИДС-ийн 100 эмэгтэй суралцагчид 64 эрэгтэй суралцагч ногдож байна. Энэ харьцаа 2014 оноос хойш тасралтгүй буурсан байна.


ЗУРАГ 5.16. ТБМБСБ, ИДС-Д СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010-2020 ОН



Зураг 5.17-д боловсролын шатлал тус бүрийн үндсэн багшийг хүйсээр, 2010 оноос хойш харуулсан бөгөөд зургаас харахад 2019/2020 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын байгууллагад ажиллаж буй үндсэн багш нарын 96.8 хувь нь эмэгтэй, ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн багш нарын 81.5 хувь эмэгтэй, техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага (ТБМБСБ)-ын багш нарын 64.9 хувь нь эмэгтэй, их, дээд сургууль (ИДС)-ийн багш нарын 61.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Эндээс бүх шатны боловсролын байгууллагын багш нарын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа нь харагдана.

Нарийвчлан харвал СӨБ болон ЕБС-ийн багш нарын дийлэнх нь эмэгтэйчүүд байна. Эдгээр шатлалын эмэгтэй багш нарын эзлэх хувийг 2010/2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад бага зэрэг буурсан байна.

ЗУРАГ 5.17. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БАГШ, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010-2020 ОН




Хүн амын, ялангуяа 6-15 насны охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын байдлыг илэрхийлдэг өөр нэг үзүүлэлт бол сургуулийн гадна байгаа буюу сургууль завсардсан¹⁸ хүүхдийн тоо юм.

Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 6-15 насны сургууль завсардсан 11.4 мянган хүүхэд байгаа бөгөөд 55.9 хувь нь хөвгүүд, 44.1 хувь нь охид байна. Сургууль завсардсан хүүхдийн бараг тал хувь (46.8 хувь) нь 6 настнууд, тэдгээрийн 53.4 хувь нь хөвгүүд байна. Мөн 7-9 настнуудын эзлэх хувь их байна (Зураг 5.18).

18 Сургуульд суралцаж байгаад завсардсан болон сургуульд огт суралцаагүй бүх хүүхэд


Нас ахих тутам сургууль завсардагчдын эзлэх хувь буурч байна. Харин 15 насанд бага зэрэг өссөн бөгөөд тэднийг хүйсээр харахад ихэнх хувь (72.1 хувь)-ийг хөвгүүд эзэлж байна.

ЗУРАГ 5.18. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



2020 оны энэхүү суваргыг 2010 оныхтой харьцуулахад эсрэг дүр зураг харагдаж байна. 2010 оны үед өсвөр насныхны сургууль завсардалт өндөр хувьтай байсан бол 2020 онд огцом буурчээ. Энэ нь МСҮТ-д суралцагчдыг дэмжих бодлого явуулсантай холбоотой байж болох юм.

ЗУРАГ 5.19. СУРГУУЛЬ ЗАВСАРДСАН 6-15 НАСНЫ ХҮҮХЭД, ХҮЙС, БҮСЭЭР, 2020 ОН



Зураг 5.19-өөс харахад сургууль завсардсан 6-15 насны хүүхдийн 18.8 хувь нь Баруун бүсэд, 10.9 хувь нь Хангайн бүсэд, 6.5 хувь нь Төвийн бүсэд, 2.7 хувь нь Зүүн бүсэд байгаа бол хамгийн их (61.1 хувь) нь Улаанбаатар хотод байна.

Сургууль засвардсан хөвгүүдийн эзлэх хувь бүх бүсэд охидоосоо өндөр байна.

Сургууль завсардсан хүүхдийн тоогоор Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Увс, Сэлэнгэ, Баянхонгор, Хэнтий, Төв, Архангай аймаг тэргүүлж байна. Сургууль завсардсан хөвгүүдийн тоо нас харгалзахгүйгээр бүх аймагт охидоос олон байгааг Хүснэгт 5.8-аас харж болно. Зөвхөн Орхон аймгийн 12-15 насны бүлэгт, Дархан-Уул аймгийн 6-11 насны бүлэгт охид хөвгүүдээс их байна.

ХҮСНЭГТ 5.8. ЗУРГААГААС АРВАН ТАВАН НАСНЫ ХҮҮХДИЙН СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТ, НАСНЫ БҮЛЭГ, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР, ХУВИАР, 2020 ОН

Аймаг, нийслэл	Бүгд			6-11 нас			12-15 нас		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	55.9	44.1	100.0	54.2	45.8	100.0	65.3	34.7
БАРУУН БҮС	100.0	57.0	43.0	100.0	55.1	44.9	100.0	68.4	31.6
Баян-Өлгий	100.0	54.5	45.5	100.0	54.7	45.3	100.0	51.1	48.9
Говь-Алтай	100.0	72.7	27.3	100.0	60.0	40.0	100.0	85.5	14.5
Завхан	100.0	63.9	36.1	100.0	60.2	39.8	100.0	73.5	26.5
Увс	100.0	67.4	32.6	100.0	59.7	40.3	100.0	79.3	20.7
Ховд	100.0	52.5	47.5	100.0	52.0	48.0	100.0	55.8	44.2
ХАНГАЙН БҮС	100.0	65.4	34.6	100.0	61.5	38.5	100.0	74.0	26.0
Архангай	100.0	64.8	35.2	100.0	59.3	40.7	100.0	72.1	27.9
Баянхонгор	100.0	71.6	28.4	100.0	69.9	30.1	100.0	73.2	26.8
Булган	100.0	60.0	40.0	100.0	60.4	39.6	100.0	58.6	41.4
Орхон	100.0	64.9	35.1	100.0	71.6	28.4	100.0	48.1	51.9
Өвөрхангай	100.0	65.9	34.1	100.0	58.9	41.1	100.0	77.8	22.2
Хөвсгөл	100.0	64.7	35.3	100.0	60.0	40.0	100.0	86.5	13.5
ТӨВИЙН БҮС	100.0	60.9	39.1	100.0	55.4	44.6	100.0	75.7	24.3
Говьсүмбэр	100.0	66.7	33.3	100.0	76.9	23.1	100.0	50.0	50.0
Дархан-Уул	100.0	51.5	48.5	100.0	45.0	55.0	100.0	77.8	22.2
Дорноговь	100.0	66.0	34.0	100.0	59.7	40.3	100.0	76.9	23.1
Дундговь	100.0	66.7	33.3	100.0	51.5	48.5	100.0	85.2	14.8
Өмнөговь	100.0	59.6	40.4	100.0	54.8	45.2	100.0	69.4	30.6
Сэлэнгэ	100.0	60.8	39.2	100.0	61.3	38.7	100.0	58.6	41.4
Төв	100.0	64.1	35.9	100.0	54.7	45.3	100.0	91.7	8.3
ЗҮҮН БҮС	100.0	67.9	32.1	100.0	59.7	40.3	100.0	79.8	20.2
Дорнод	100.0	61.6	38.4	100.0	56.1	43.9	100.0	68.8	31.3
Сүхбаатар	100.0	83.5	16.5	100.0	64.5	35.5	100.0	94.4	5.6
Хэнтий	100.0	61.9	38.1	100.0	59.6	40.4	100.0	68.4	31.6
УЛААНБААТАР	100.0	52.8	47.2	100.0	52.7	47.3	100.0	53.4	46.6

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор боловсролын үзүүлэлтүүд 2010 оны тооллогоос өсөж, харин 10 болон түүнээс дээш насны хүн амд боловсролгүй хүнийн эзлэх хувь буурсан.

Боловсролтой 10, түүнээс дээш насны хүн амын дүнд эзлэх хувь 95.1 болж өмнөх тооллогын үеэс 2.6 пунктээр өссөн байна. Хүйсийн ялгаатай байдлаар харвал эрэгтэйчүүдийнх 2.7 пунктээр, эмэгтэйчүүдийнх 2.3 пунктээр өсжээ. Боловсролгүй хүн амын эзлэх хувь 4.9 болж өмнөх тооллогын дүнгээс 2.6 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Боловсролгүй 10, түүнээс дээш насны хүн амын дүнд эзлэх хувь 4.9 болж, 2.6 пунктээр буурсны дотор эрэгтэйчүүдийнх 2.7 пунктээр буурчээ.

ХҮСНЭГТ 5.9. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Боловсролын түвшин	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	7.5	8.0	6.9	4.9	5.3	4.6
Боловсролтой	92.5	92.0	93.1	95.1	94.7	95.4
Бага	15.8	16.6	15.0	13.7	14.6	12.8
Суурь	17.9	20.3	15.6	17.1	19.2	15.1
Бүрэн дунд	32.0	32.2	31.9	29.2	30.8	27.7
Техникийн болон мэргэжлийн	2.8	3.1	2.6	3.9	4.3	3.4
Тусгай мэргэжлийн дунд	5.7	4.6	6.9	4.7	4.1	5.3
Дээд	18.3	15.4	21.2	26.5	21.7	31.1

Харин 10, түүнээс дээш насны нийт хүн амын 26.5 хувь нь дээд боловсролтой байгааг хүйсээр харвал эрэгтэйчүүдийн 21.7 хувь, эмэгтэйчүүдийн 31.1 хувь нь дээд боловсролтой байна.

Боловсрол эзэмшигчдийг хүйсээр ангилж үзэхэд нэлээд ялгаатай талууд ажиглагдаж байна. Ялангуяа өмнөх тооллогоор дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 5.8 пунктээр илүү байсан бол 2020 онд тус зөрүү нь 9.4 пункт болж нэмэгджээ.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 29.2 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Хүйсээр авч үзвэл боловсролтой эрэгтэйчүүдийн 19.1 хувь нь, эмэгтэйчүүдийн 26.8 хувь нь бакалаврын дээд боловсролтой байна (Зураг 5.20). Тусгай мэргэжлийн дунд боловсролоос эхлэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж эхэлжээ.

ЗУРАГ 5.20. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН



Боловсролтой иргэдийн 48.4 хувь нь эрэгтэй, 51.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Өмнөх 2010 оны тооллогын дүнгээр боловсролтой 10-34 насны иргэдийн хувьд хүйсийн ялгаа их байснаа 35 наснаас буурч, эргээд 60 наснаас нэмэгдэж эхэлжээ. Харин 2020 онд боловсролтой иргэдийн хүйсийн ялгаа эрс багасч, 35-39 болон 70, түүнээс дээш насанд зөрүү ихтэй байна. 2010 онд 55 наснаас эхлэн боловсролтой эрэгтэйчүүд давамгайлж байсан бол 2020 онд 10 насаар ухарч, 65 болжээ.


ХҮСНЭГТ 5.10. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙС, НАСНЫ БҮЛГЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Хүйсийн ялгаа*	
	2010	2020	2010	2020	2010	2020	2010	2020
БҮГД	92.5	95.1	92.0	94.7	93.1	95.4	1.1	0.7
10-14	67.0	71.5	66.0	71.3	68.1	71.8	2.0	0.5
15-19	96.6	97.9	95.5	97.5	97.7	98.4	2.2	0.9
20-24	96.0	98.3	94.7	97.9	97.3	98.6	2.5	0.7
25-29	93.9	98.4	92.3	98.0	95.6	98.8	3.2	0.8
30-34	96.3	98.1	95.3	97.7	97.4	98.5	2.0	0.9
35-39	97.9	97.4	97.5	96.8	98.3	97.9	0.8	1.0
40-44	97.5	98.3	97.2	97.9	97.8	98.6	0.6	0.7
45-49	96.9	98.6	96.7	98.4	97.0	98.8	0.4	0.4
50-54	96.9	98.4	96.9	98.2	96.9	98.5	0.0	0.3
55-59	96.3	98.2	96.5	98.1	96.1	98.2	-0.4	0.2
60-64	95.4	98.3	96.5	98.3	94.5	98.3	-2.0	0.0
65-69	91.6	98.0	94.1	98.3	89.5	97.8	-4.7	-0.5
70, түүнээс дээш	81.0	95.2	87.3	97.2	76.3	94.0	-11.0	-3.2

Тайлбар: * эмэгтэй-эрэгтэй


Дээд боловсролтой эмэгтэйчүүд 20-иос дээш насны бүх бүлэгт эрэгтэйчүүдээс их, зөвхөн 70-аас дээш насанд л эрэгтэйчүүдийн тоо их байна. Харин 40-өөс дээш насанд тусгай мэргэжлийн дунд боловсролтой эрэгтэйчүүд давамгайлж байна.

ЗУРАГ 5.21. ДЭЭД БОЛОН ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Арван тав ба түүнээс дээш насны тусгай мэргэжлийн дундаас дээш боловсролтой хүн амыг насны бүлгээр харахад эмэгтэйчүүд бүх насны бүлэгт эрэгтэйчүүдээс их байна. Харин 2010 оны хувьд 55-аас дээш насанд эрэгтэйчүүд давамгайлж байжээ.

ЗУРАГ 5.22. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ДУНДААС ДЭЭШ БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМ, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2010, 2020 ОН




ДҮГНЭЛТ

- Сургуульд хамрагдалтад гарсан томоохон өөрчлөлт бол сургуульд хамрагдагчдын хувьд хүйс болон хот, хөдөөгөөр ялгаварлахгүй бүх ангилалд нэлээд нэмэгджээ.
- Сургуульд суралцаж буй хүн амын хүйсийн ялгаа 15 наснаас эхлэн насны бүлэг нэмэгдэх тутам ихсэж байгаа бөгөөд 16-19 насанд хүйсийн ялгаа хамгийн их байна. Нас ахих тутам сургуульд хамрагдалт буурч байгаа энэ хандлага эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү ажиглагдаж байна.
- Боловсролын шатлал ахихад сургуульд хамрагдаж байгаа хөвгүүдийн тоо цөөрч, охид давамгайлах хандлагатай болж байна.
- ЕБС-ийн бага ангид суралцаж байгаа эрэгтэй хүүхдийн тоо их байсан бол дунд, ахлах ангид эмэгтэй хүүхдийн тоо их байна.
- Техникийн болон мэргэжлийн боловсролд суралцаж буй суралцагчдыг сонгон суралцаж буй салбар болон хүйсээр харвал уул уурхай, тээвэр, барилга, хөдөө аж ахуйн салбарт суралцагчдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа бол эрүүл мэнд, үйлчилгээ болон мэргэжлийн бусад салбарт суралцагчдын дийлэнхийг эмэгтэйчүүд эзэлж байна.
- Бакалавраас дээш зэрэгт суралцагчдын 55.0-аас дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь эмэгтэйчүүд мэргэжилтэй ажилтан болохын оронд дээд боловсрол эзэмшихийг илүүд үзэж байгаа нь харагдаж байна.
- Боловсрол, анагаах, хүмүүнлэг болон нийгмийн салбарын мэргэжилтэн болохоор их, дээд сургуульд суралцагчдын дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ хандлага 2010 оноос хойш өнөөг хүртэл өөрчлөгдсөнгүй хадгалагдсаар иржээ.
- Мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцагчдын хүйсийн харьцааг 2010 оноос хойш харвал, энэ салбарт суралцагчдын дунд эрэгтэйчүүд байнга давамгайлсаар иржээ.
- Бүх шатны боловсролын байгууллагын багш нарын дийлэнх нь эмэгтэйчүүд байна.
- 2010 оны үед өсвөр насныхны сургууль завсардалт өндөр хувьтай байсан бол 2020 онд огцом буурчээ. Энэ нь МСҮТ-д суралцагчдыг дэмжих бодлого явуулсантай холбоотой байж болох юм.
- Сургууль завсардсан хүүхдийн тоогоор Улаанбаатар хот болон Баян-Өлгий, Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Увс, Сэлэнгэ, Баянхонгор, Хэнтий, Төв, Архангай аймаг тэргүүлж байна. Сургууль завсардсан хөвгүүдийн тоо нас харгалзахгүйгээр бүх аймагт охидоос олон байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЭРХ МЭДЭЛ, ШИЙДВЭР ГАРГАЛТ




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ЭРХ МЭДЭЛ, ШИЙДВЭР ГАРГАЛТ

Монгол Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нарийвчилсан мэдээллийг ҮСХ-ноос улирал болгон зохион байгуулан явуулдаг “Ажиллах хүчний судалгаа(АХС)”, сар бүр гаргадаг “Ажилгүй иргэдийн мэдээ” мөн 10 жил тутамд зохион байгуулдаг Хүн ам, орон сууцны тооллогоор гаргаж байна. Харин энэ хэсэгт “Ажиллах хүчний судалгаа”-ны мэдээлэлд үндэслэн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээллийг хүйсийн ялгаатай байдлаар тодорхойлохыг зорилоо.

АХС-гаар 2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1146.2 мянган ажиллагч байгаа бөгөөд энэ нь ажиллах хүчний 90.0 хувь байна. Харин 127.7 мянган ажилгүй иргэд байгаа нь ажиллах хүчний 10.0 хувьтай тэнцүү байна.


ЗУРАГ 6.1. АЖИЛЛАГЧИД БОЛОН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, СОНГОСОН ОНООР



Ажиллагчид болон ажилгүй иргэдийг хүйсээр харвал ихэвчлэн ажиллагчдын 50.0-53.0 хувь нь, ажилгүй иргэдийн 46.0-58.0 хувь нь эрэгтэйчүүд байна. Динамик тооноос харахад ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувьд онцын өөрчлөлт гарч хэлбэлзсэнгүй, зөвхөн 2005 онд 49.5 хувь болж байжээ. Харин ажилгүй иргэдийн тоо 2010 он болон 2016-2019 онуудад 100.0 мянгаас дээш гарсан бөгөөд ажилгүй иргэдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй нэмэгдсээр байна. Тухайлбал, 2005 онд ажилгүй иргэдийн дунд эрэгтэйчүүд 44.3 хувийг эзэлж байсан бол 2016 онд 62.1 хувь, 2019 онд 58.9 хувийг эзэлж байна.

Ажилгүй иргэдийн тоог 2005 оноос өмнө “Хөдөлмөрийн нөөцийн баланс”-аар тооцон гаргадаг байсан бөгөөд энд зөвхөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоог авдаг байсан.

ЗУРАГ 6.2. АЖИЛЛАГЧИД БОЛОН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, ХҮЙСЭЭР, СОНГОСОН ОНООР



*- 2005 оноос өмнө Хөдөлмөрийн нөөцийн баланс буюу зөвхөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоог гаргадаг байсан.

Түүнчлэн ажиллагчид болон ажилгүй иргэдийн хүйсийн харьцааг дараах зургаас харахад илүү тодорхой

харагдана. Ажиллагчдын хүйсийн харьцаа харьцангуй тогтвортой бөгөөд эрэгтэйчүүд бага зэрэг илүү байгаа бол ажилгүй иргэдийн хувьд нэлээд савалгаатай байна. Ажилгүй иргэдийн хүйсийн харьцааг харвал 2010 оноос хойш ажилгүйчүүдийн дунд эрэгтэйчүүд давамгайлах болжээ.

ЗУРАГ 6.3. АЖИЛЛАГЧИД БОЛОН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦАА, СОНГОСОН ОНООР




Тухайлбал, 2010 онд болон 2014 оноос хойш ажилгүй 100 эмэгтэйд 130-аас дээш эрэгтэй ногдож байна. Энэ харьцаа 2016 онд хамгийн өндөр түвшинд хүрч, 164 болжээ.

Тухайн улс орны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хэмждэг гол үзүүлэлт бол ажиллах хүчний оролцооны түвшин¹⁹ (АХОТ), хөдөлмөр эрхлэлтийн түвшин (ХЭТ), ажилгүйдлийн түвшин²⁰ (АТ) зэрэг үзүүлэлтүүд юм.

АХОТ-г тооцсоноор хүн амын хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцооны өөрчлөлт, хөдөлгөөн насны бүлгээр хэрхэн өөрчлөгдөж буйг харах боломжтой байдаг. АХОТ-г насны бүлэг болон хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийн АХОТ бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийнхээс их байна. Түүнчлэн 25-29 болон 55-59 насны бүлэгт эрэгтэйчүүдийн АХОТ эмэгтэйчүүдийнхээс 23.3-29.3 пунктээр их байна.

ЗУРАГ 6.4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, 2019 ОН



Энэ нь залуу насны эмэгтэйчүүд сурах, хүүхдээ асрах зэрэг шалтгаанаар хөдөлмөр эрхлэхгүй байх, 55-аас дээш насанд эмэгтэйчүүд өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой юм.


Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар ажиллах хүч (15 ба түүнээс дээш нас)-ний 99.2 хувь буюу 1264.4 мянгань 18, түүнээс дээш насныхун ам байна. Эдгээр хүн амын АХОТ гэрлэлтийн байдалтай ямар хамааралтай байгааг авч үзвэл бэлэвсэн хүн ам (хүйсийн хувьд ялгаа багатай)-ын хувьд АХОТ хамгийн доогуур буюу

19 Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно. “Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”, УСХ, 2019 он

20 Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно. “Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”, УСХ, 2019 он

26.6 хувь байна. Түүнчлэн хүйсээр харвал тусгаарласан болон гэрлэлтээ цуцалсан эмэгтэйчүүдийн АХОТ хамгийн их байна. Харин батлуулаагүй гэр бүлтэй болон огт гэрлээгүй эмэгтэйчүүдийн АХОТ бусдаас бага байна.


ЗУРАГ 6.5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, ХҮЙСЭЭР, 2019 ОН



Батлуулсан болон батлуулаагүй гэр бүлтэй эрэгтэйчүүдийн АХОТ хамгийн өндөр байгаа нь Зураг 6.5-д харагдана.


Мөн АХОТ-г динамик байдлаар харвал эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс байнга өндөр байдаг байна.

ЗУРАГ 6.6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ХҮЙСЭЭР, СОНГОСОН ОНООР



Улсын хэмжээнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин²¹ 54.4 хувь, эрэгтэйчүүдийнх 60.8 хувь, эмэгтэйчүүдийнх 48.7 хувь байна.

ЗУРАГ 6.7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ХҮЙСЭЭР, 2019 ОН




21 Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно. "Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлал", ҮСХ, 2019 он

Дээрх зургаас харахад бүх байршлын хувьд эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эмэгтэйчүүдийнхээс их, тэр дундаа хөдөөд нэлээд өндөр байна.

Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг хүн амын боловсролын түвшинтэй холбож харвал боловсролын түвшин дээшлэх тутам ХЭТ нэмэгдсэн байна. Энэ нь хүйсийн хувьд адилхан байгаа бөгөөд бага боловсролтой иргэдийн ХЭТ хамгийн бага байна.

ЗУРАГ 6.8. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, 2019 ОН




Ажиллах хүчний судалгааны дүнгээр Монгол Улсын хэмжээнд ажиллах хүчний 90.0 хувь буюу 1146.2 мянга нь ажиллагчид байгааг өмнө дурдсан. Эдгээр ажиллагчдын 52.9 хувь буюу 606.8 мянга нь эрэгтэйчүүд, 47.1 хувь буюу 539.4 мянга нь эмэгтэйчүүд байна.

Ажиллагчдыг боловсролын түвшин болон хүйсээр ангилж харвал ажиллагч 10 хүн тутмын 3 нь бакалаврын болон дипломын дээд боловсролтой байна. Энэ хандлага эмэгтэй ажиллагчдын хувьд хадгалагдаж байсан бол эрэгтэй ажиллагчдын хувьд 10 хүн тутмын 3 нь техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшжээ.


Түүнчлэн доорх зургаас харахад тусгай мэргэжлийн дунд боловсролтой ажиллагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 61.4, докторын зэрэгтэй ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр (78.7 хувь) байна.

ЗУРАГ 6.9. АЖИЛЛАГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН




Ажиллагчдыг тэдгээрийн ажиллаж буй салбараар авч үзвэл тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, барилга, уул уурхай, олборлолт зэрэг салбарт ажиллагчдын дийлэнх буюу 79.6-86.5 хувь нь эрэгтэйчүүд байгаа бол бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын дийлэнх (56.6-84.3 хувь) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 6.10. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Мөн ажиллагчдыг ажил мэргэжлийн ангилал, хүйсээр харахад үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, зэвсэгт хүчний ажил, мэргэжил, суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч мэргэжлээр ажиллагчдын 68.3-95.1 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.


ЗУРАГ 6.11. АЖИЛЛАГЧИД, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН АНГИЛАЛ, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Харин мэргэжилтэн, худалдаа болон контор, үйлчилгээний ажил мэргэжлийн ажлыг дийлэнхдээ (62.1-78.8 хувь) эмэгтэйчүүд хийж байна.

Мөн түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийн статусаар тооцож үзвэл хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүдийн 70.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь хөлсгүй хөдөлмөр хийж байгаа эмэгтэйчүүд их байгааг харуулж байна.


ЗУРАГ 6.12. АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУС²², ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



АХС-гаар 2019 оны байдлаар улсын хэмжээнд нийт 127.7 мянган ажилгүй иргэн байна. Эдгээрийн 58.9 хувь буюу 75.2 мянга нь эрэгтэйчүүд, 41.1 хувь буюу 52.5 мянга нь эмэгтэйчүүд байна.

Монгол Улсын ажилгүйдлийн түвшин 2019 онд 10.0 хувь байна. Хүйсээр харвал эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 11.0 хувь байгаа нь эмэгтэйчүүдийнхээс 2.1 пунктээр илүү байна.

ЗУРАГ 6.13. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, СОНГОСОН ОНООР




Өмнөх зургаас харахад 2010 оноос хойш зөвхөн 2013 онд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдээс давсан бол бусад бүх онуудад эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс их байжээ.

Ажилгүй иргэдийг насны бүлэг, хүйсээр тооцож үзвэл тухайн насны бүлэг дэх ажилгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь 20-34 насанд эрэгтэйчүүдээс их байгаа бол 35-54 насанд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс их байгаа нь доорх зургаас харагдана. Энэ нь мөн л залуу эмэгтэйчүүдийн сурч боловсрох, хүүхэд төрүүлж, асарч байгаатай холбоотой нь илрэн гарч байна.

22 Ажиллагчийг эдийн засгийн нэгж болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно. “Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлал”, УСХ, 2019 он


ЗУРАГ 6.14. АЖИЛГҮЙ ХҮН, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2019 ОН



Мөн хөдөлмөр эрхэлж байгаа хүн амын дундаж цалингийн хүйсийн ялгаатай байдлыг авч үзье. Энэхүү мэдээллийг НДЕГ-ын шимтгэл төлөлтийн тайланд үндэслэн тооцож гаргасан ажиллагчдын сарын дундаж цалингийн мэдээгээр гаргав. ААНБ-ын ажиллагчдын шимтгэл төлөлтийн тайлангаас тооцон гаргасан ажиллагчдын сарын дундаж цалин 2019 онд 1124.3 мянган төгрөг байна. Түүнчлэн эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй ажиллагчдын сарын дундаж цалингаас илүү байх хандлага хадгалагдсаар байна.

Зураг 6.15-аас харахад улсын дундаж цалин эмэгтэйчүүдийн дундаж цалингаас үргэлж их харин эрэгтэйчүүдийнхээс бага байгаа нь харагдана. Мөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү нэмэгдсээр байгааг харж болно.

ЗУРАГ 6.15. ААНБ-ЫН АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, ХҮЙСЭЭР, 2010-2019 ОН



Эх үүсвэр: УЦХ, ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалингийн улирлын мэдээ, 2019 он

Эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин эмэгтэй ажиллагчдынхаас 2019 онд 201.4 мянган төгрөг буюу 19.7 хувиар их байна. Эрэгтэй, эмэгтэй ажиллагчдын цалингийн зөрүүг өмнөх онтой харьцуулахад 4.4 мянган төгрөгөөр нэмэгджээ. Эрэгтэйчүүдийн дундаж цалинд эмэгтэйчүүдийн цалингийн эзлэх хувь 2019 онд 83.5 болж, өмнөх оноос 1.4 пунктээр нэмэгдсэн байна.

Монгол Улс нь тэгш шан хөлс олгох тухай НҮБ-ын 100 дугаар конвенц (1969)-д нэгдэн орсон орны нэг бөгөөд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно хэмээн заасан. Монгол Улсын эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 83.5 хувь байгаа нь дэлхийн дунджаас дээгүүр боловч 2015 онтой харьцуулахад 5.2 пунктээр буурсан байна.


Хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар холбогдох мэдээллийг энэ хэсэгт дурдаж байна. Эдгээр мэдээллийг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), Төрийн албаны зөвлөл (ТАЗ) болон аймгийн Засаг даргын дэргэдэх тамгын газрын мэдээлэлд үндэслэн гаргалаа.

Түүхийн хуудсыг сөхвөл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын их хурлын 430 депутатаас сонгогдсон, 50 гишүүнтэй Улсын бага хурал нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд 2 эмэгтэй гишүүнтэй байжээ. Үүний дараа МУ-ын шинэ Үндсэн хууль батлагдаж, парламентын тогтолцоонд шилжин, 1992 оны Монгол Улсын Их Хурлын анхны сонгуульд 293 хүн нэр дэвшиж, 76 гишүүн сонгогдсоноос 5.3 хувь нь буюу 4 нь эмэгтэй гишүүн байлаа.

МУ-ын УИХ-ын сонгуульд өрсөлдөхөөр нэр дэвшигчдийг хүйсээр, түүнчлэн нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг сонгуулийн оноор харвал 2000 болон 2020 онд хамгийн олон хүн сонгуульд өрсөлдөж байжээ. Тухайлбал, 2000 онд 602 хүн, 2020 онд 606 хүн нэр дэвшсэн байна.


Доорх зургаас харахад сонгуульд нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2004 оноос эхлэн огцом өсөж, 10.0 хувиас дээш гарсан байна. УИХ-д нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш бага байгаа бөгөөд 2012 онд хамгийн их буюу 32.0 хувьд хүрч байжээ. Гэсэн хэдий ч уг үзүүлэлт буурч сүүлийн 2 удаагийн сонгуульд нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурсаар байна.

ЗУРАГ 6.16. УИХ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН ТОО, ХҮЙСЭЭР, НЭР ДЭВШСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СОНГУУЛИЙН ОНООР



Харин УИХ-д нэр дэвшигчдээс сонгогдож, УИХ-ын гишүүн болсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2004, 2008 онд буурч, 2008 онд 3.9 хувь болж байсан бол сүүлийн жилүүдэд өсөж, 17.1 хувьд хүрсэн эерэг дүр зурагтай байна.

ЗУРАГ 6.17. УИХ-Д СОНГОГДСОН ГИШҮҮДИЙН ТОО, ХҮЙСЭЭР, СОНГОГДСОН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СОНГУУЛИЙН ОНООР




УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо өсөж байгаа хэдий ч МУ-ын УИХ-ын даргаар ажилласан эмэгтэй гишүүн өнөөг хүртэл байхгүй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 7 удаагийн сонгуульд нийт 16 хүн нэр дэвшиж байснаас 2013 оны сонгуульд 1 эмэгтэй нэрээ дэвшүүлж байжээ.

Түүнчлэн орон нутгийн хувьд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо буюу 2020 оны аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигч болон сонгогчдын хүйсийн ялгаатай байдлыг дараах 2 зурагт харуулаа.

ЗУРАГ 6.18. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-Д НЭР ДЭВШСЭН ХҮНИЙ ТОО, ХҮЙСЭЭР, НЭР ДЭВШСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМГААР




Зураг 6.18-д аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д нэр дэвшигчдийг аймгаар хүйсээр харуулсан бөгөөд Сүхбаатар, Ховд, Булган, Дорноговь аймгаас аймгийнхаа ИТХ-д нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн их (24.6-27.7 хувь) байна. Харин Архангай, Дархан-Уул аймгаас нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага (11.8-13.2 хувь) байна.

Мөн нийслэлийн 2020 оны ИТХ-д нийт 205 хүн нэрээ дэвшүүлснээс 85 эмэгтэй байгаа бөгөөд нийт нэр дэвшигчдийн 29.3 хувийг эзэлж байгаа нэлээд нааштай үзүүлэлт юм.


Түүнчлэн нэр дэвшигчдээс аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон иргэдийг хүйсээр тооцвол дараах байдалтай байна. Аймаг, нийслэлийн ИТХ нь нийт 817 мандаттай бөгөөд нийт мандатын 131 буюу 16.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Эдгээр мандатыг аймаг, нийслэл болон сонгогчдын хүйсээр тооцож үзвэл Дорноговь, Архангай, Төв аймгийн ИТХ-д сонгогдсон нийт хүний 21.2-24.4 хувийг эмэгтэйчүүдийн эзэлж байгаа нь хамгийн өндөр дүнтэй байна. Харин Увс аймгийн ИТХ-д суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага буюу 9.8 хувь өөрөөр хэлбэл, 10.0 хувь ч хүрэхгүй байна.

ЗУРАГ 6.19. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИТХ-Д СОНГОГДСОН ХҮНИЙ ТОО, ХҮЙСЭЭР, ИТХ-Д СОНГОГДСОН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМГААР




Үүний зэрэгцээ МУ-ын засаг захиргааны анхдагч нэгжийн нэг болох сум, дүүргийн ИТХ-д сонгогдсон иргэдийг хүйсээр харвал, Сэлэнгэ, Дорноговь, Төв, Дархан-Уул аймгийн сумдын ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 36.0-40.2 хувь байна. Харин зөвхөн Баян-Өлгий аймгийн сумдын ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь (15.8 хувь) 20.0 хувьд ч хүрэхгүй байгаа нь дараах зургаас харагдана.

ЗУРАГ 6.20. СУМЫН ИТХ-Д СОНГОГДСОН ХҮНИЙ ТОО, ХҮЙСЭЭР, СОНГОГДСОН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, АЙМГААР




Түүнчлэн дүүргээр ангилж үзэхэд Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн ИТХ нь хамгийн олон суудалтай байна. Гэвч Хан-Уул, Баянзүрх дүүргийн ИТХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь хамгийн бага буюу 17.1-18.6 хувь байна. Харин Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Багахангай дүүргийн ИТХ-д сонгогдсон иргэдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 30.0-аас дээш байна.

ЗУРАГ 6.21. УЛААНБААТАР ХОТЫН ДҮҮРГИЙН ИТХ-Д СОНГОГДСОН ХҮНИЙ ТОО, ХҮЙСЭЭР, СОНГОГДСОН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, ДҮҮРГЭЭР



Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо улс төрийн түвшинд харилцан адилгүй байна. Тухайлбал, 2020 оны байдлаар Засгийн газрын сайд нарын түвшинд нийт сайдын 17.6 хувь, дэд сайдын 14.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол аймаг, нийслэлийн Засаг даргаар нэг ч эмэгтэй хүн ажиллаагүй байна.

ЗУРАГ 6.22. ЗАСГИЙН ГАЗРЫН САЙД, ДЭД САЙДЫН ТОО, ХҮЙСЭЭР, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, СОНГОСОН ОНООР



ДҮГНЭЛТ

- Ажилгүй иргэдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь тасралтгүй нэмэгдсээр байна.
- Ажиллагчдын хүйсийн харьцаа харьцангуй тогтвортой бөгөөд эрэгтэйчүүд бага зэрэг илүү байгаа бол ажилгүй иргэдийн хувьд нэлээд савалгаатай байна. Ажилгүй иргэдийн хүйсийн харьцааг харвал 2010 оноос хойш ажилгүйчүүдийн дунд эрэгтэйчүүд давамгайлах болжээ.
- 25-29 насны эмэгтэйчүүдийн АХОТ эрэгтэйчүүдээс бага байгаа нь залуу насны эмэгтэйчүүд сурах, хүүхдээ асрах зэрэг шалтгаанаар хөдөлмөр эрхлэхгүй байх, 55-аас дээш насанд эмэгтэйчүүд өндөр насны тэтгэвэрт гардагтай холбоотой юм.
- Тусгаарласан болон гэрлэлтээ цуцалсан эмэгтэйчүүдийн АХОТ хамгийн их байна. Харин батлуулаагүй гэр бүлтэй болон огт гэрлээгүй эмэгтэйчүүдийн АХОТ бусдаас бага байна.
- АХОТ-ны динамикийг харвал эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс байнга өндөр байдаг байна.
- Эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эмэгтэйчүүдийнхээс их, тэр дундаа хөдөөд нэлээд өндөр байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг хүн амын боловсролын түвшинтэй холбож харвал боловсролын түвшин дээшлэх тутам ХЭТ нэмэгдсэн байна. Энэ нь хүйсийн хувьд адилхан байгаа бөгөөд бага боловсролтой иргэдийн ХЭТ хамгийн бага байна.
- Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүний ажил хийж байгаа иргэдийн ихэнхийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь өрхийн аж ахуй болон өрхөд хөлсгүй хөдөлмөр хийж байгаа эмэгтэйчүүд их байгааг харуулж байна.
- 2010 оноос хойш зөвхөн 2013 онд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдээс давсан бол бусад бүх онуудад эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс их байжээ.
- Улсын дундаж цалин эмэгтэйчүүдийн дундаж цалингаас үргэлж их харин эрэгтэйчүүдийнхээс бага байна. Мөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү нэмэгдсээр байна.
- УИХ-ын сүүлийн 2 удаагийн сонгуульд нэр дэвшигчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурсаар байна.
- УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо өсөж байгаа хэдий ч МУ-ын УИХ-ын даргаар ажилласан эмэгтэй гишүүн өнөөг хүртэл байхгүй байна.
- УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх сонгуулийн жилийн түвшинд байна.
- Аймгийн ИТХ-д сонгогдсон иргэдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 30.0 хүрэхгүй байхад сум, дүүргийн ИТХ-д сонгогдсон иргэдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэлээд өндөр буюу 30.0-аас дээш хувийг эзэлж буй аймаг 8 байна. Эндээс Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасаны заалтын хэрэгжилтийг дүгнэх боломжтой болох юм. Тухайлбал:
 - Аймаг, нийслэлд 15 хувиас доошгүй байх (Нийслэл болон 21 аймгаас 11 нь 15.0 хувиас дээш байна).
 - Дүүрэгт 20 хувиас доошгүй байх (9 дүүрэгт 7 нь 20.0 хувиас дээш байгаа бөгөөд Чингэлтэй, Баянзүрх дүүрэгт 20.0 хувиас бага байна).
 - Суманд 25 хувиас доошгүй байх (нийт дүнгээр 21 аймгийн сумын ИТХ-ээс 14 аймгийн ИТХ-ын гишүүдийн 25.0-аас дээш хувь эмэгтэйчүүд байна).



ХАВСРАЛТ
ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1. Хүн амын тоо, хүйсийн харьцаа, сонгосон онуудаар

Үзүүлэлтүүд	Тоо /мян. хүн/	Хувь	Хүйсийн харьцаа	Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа
1900 Бүгд	636.7	100.0		2000 Бүгд	2 403 105	100.0	
1900 Эрэгтэй	324.7	51.0	104.1	2000 Эрэгтэй	1 190 244	49.5	98.1
1900 Эмэгтэй	312.0	49.0		2000 Эмэгтэй	1 212 861	50.5	
1918 Бүгд	647.5	100.0		2004 Бүгд	2 521 733	100.0	
1918 Эрэгтэй	330.2	51.0	104.1	2004 Эрэгтэй	1 251 052	49.6	98.5
1918 Эмэгтэй	317.3	49.0		2004 Эмэгтэй	1 270 681	50.4	
1920 Бүгд	648.7	100.0		2005 Бүгд	2 551 081	100.0	
1920 Эрэгтэй	333.4	51.4	105.7	2005 Эрэгтэй	1 265 614	49.6	98.5
1920 Эмэгтэй	315.3	48.6		2005 Эмэгтэй	1 285 467	50.4	
1925 Бүгд	651.7	100.0		2006 Бүгд	2 583 254	100.0	
1925 Эрэгтэй	331.9	50.9	103.8	2006 Эрэгтэй	1 259 653	48.8	95.2
1925 Эмэгтэй	319.8	49.1		2006 Эмэгтэй	1 323 601	51.2	
1930 Бүгд	727.4	100.0		2007 Бүгд	2 620 446	100.0	
1930 Эрэгтэй	364.5	50.1	100.4	2007 Эрэгтэй	1 277 249	48.7	95.1
1930 Эмэгтэй	362.9	49.9		2007 Эмэгтэй	1 343 197	51.3	
1935 Бүгд	738.6	100.0		2008 Бүгд	2 665 955	100.0	
1935 Эрэгтэй	370.8	50.2	100.8	2008 Эрэгтэй	1 301 305	48.8	95.4
1935 Эмэгтэй	367.8	49.8		2008 Эмэгтэй	1 364 650	51.2	
1940 Бүгд	738.6	100.0		2009 Бүгд	2 716 275	100.0	
1940 Эрэгтэй	360.5	48.8	95.3	2009 Эрэгтэй	1 328 140	48.9	95.7
1940 Эмэгтэй	378.1	51.2		2009 Эмэгтэй	1 388 135	51.1	
1944* Бүгд	759.1	100.0		2010 Бүгд	2 760 968	100.0	
1944* Эрэгтэй	371.3	48.9	95.7	2010 Эрэгтэй	1 342 081	48.6	94.6
1944* Эмэгтэй	387.8	51.1		2010 Эмэгтэй	1 418 887	51.4	
1950 Бүгд	758.9	100.0		2011 Бүгд	2 811 666	100.0	
1950 Эрэгтэй	372.9	49.1	96.6	2011 Эрэгтэй	1 364 723	48.5	94.3
1950 Эмэгтэй	386.0	50.9		2011 Эмэгтэй	1 446 943	51.5	
1956* Бүгд	845.5	100.0		2012 Бүгд	2 811 666	100.0	
1956* Эрэгтэй	420.3	49.7	98.8	2012 Эрэгтэй	1 364 723	48.5	94.3
1956* Эмэгтэй	425.2	50.3		2012 Эмэгтэй	1 446 943	51.5	
1963* Бүгд	1017.1	100.0		2013 Бүгд	2 930 277	100.0	
1963* Эрэгтэй	508.0	49.9	99.8	2013 Эрэгтэй	1 425 843	48.7	94.8
1963* Эмэгтэй	509.1	50.1		2013 Эмэгтэй	1 504 434	51.3	
1969* Бүгд	1197.6	100.0		2014 Бүгд	2 995 949	100.0	
1969* Эрэгтэй	597.4	49.9	99.5	2014 Эрэгтэй	1 466 455	48.9	95.9
1969* Эмэгтэй	600.2	50.1		2014 Эмэгтэй	1 529 494	51.1	
1975 Бүгд	1424.4	100.0		2015 Бүгд	3 057 778	100.0	
1975 Эрэгтэй	711.4	49.9	99.8	2015 Эрэгтэй	1 503 612	49.2	96.7
1975 Эмэгтэй	713.0	50.1		2015 Эмэгтэй	1 554 166	50.8	
1979* Бүгд	1595.0	100.0		2016 Бүгд	3 119 935	100.0	
1979* Эрэгтэй	798.9	50.1	100.4	2016 Эрэгтэй	1 533 983	49.2	96.7
1979* Эмэгтэй	796.1	49.9		2016 Эмэгтэй	1 585 952	50.8	
1985 Бүгд	1854.3	100.0		2017 Бүгд	3 177 899	100.0	
1985 Эрэгтэй	929.0	50.1	100.4	2017 Эрэгтэй	1 562 370	49.2	96.7
1985 Эмэгтэй	925.3	49.9		2017 Эмэгтэй	1 615 529	50.8	
1989* Бүгд	2044.0	100.0		2018 Бүгд	3 238 479	100.0	
1989* Эрэгтэй	1020.7	49.9	99.7	2018 Эрэгтэй	1 591 848	49.2	96.7
1989* Эмэгтэй	1023.3	50.1		2018 Эмэгтэй	1 646 631	50.8	
1995 Бүгд	2218.0	100.0		2019 Бүгд	3 296 866	100.0	
1995 Эрэгтэй	1102.3	49.7	98.8	2019 Эрэгтэй	1 619 573	49.1	96.6
1995 Эмэгтэй	1115.7	50.3		2019 Эмэгтэй	1 677 293	50.9	

* - Хүн амын тооллого явагдсан он

Хүснэгт 2. Хүн амын дундаж наслалт

Он	Улсын дундаж	Эрэгтэй	Эмэгтэй
1992	62.77	60.71	64.90
1995	63.78	62.10	65.43
1997	64.25	61.07	67.67
1998	65.11	62.69	67.61
2000	63.18	60.43	66.13
2001	63.36	60.66	66.26
2002	63.51	60.75	66.47
2003	63.63	60.79	66.50
2004	64.58	61.64	67.77
2005	65.21	62.11	68.61
2006	65.85	62.59	69.38
2007	66.54	63.13	70.23
2008	67.23	63.69	70.98
2009	67.96	64.33	71.79
2010	68.05	64.93	72.26
2011	68.32	64.68	73.76
2012	68.71	64.91	74.32
2013	69.11	65.42	75.01
2014	69.57	65.91	75.49
2015	69.89	66.02	75.84
2016	69.57	65.58	75.10
2017	69.89	65.88	75.44
2018	70.19	66.11	75.78
2019	70.41	66.38	75.96

Хүснэгт 3. Өрхийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйс, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2020 он

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	897 427	641 484	255 943
15-19	3 150	1 816	1 334
20-24	22 929	15 970	6 959
25-29	75 381	57 100	18 281
30-34	122 445	96 298	26 147
35-39	119 677	94 223	25 454
40-44	114 968	88 573	26 395
45-49	107 102	79 465	27 637
50-54	93 948	66 164	27 784
55-59	85 293	56 716	28 577
60-64	60 359	37 538	22 821
65-69	36 739	20 621	16 118
70+	55 436	27 000	28 436
ХОТ-БҮГД	606 282	408 931	197 351
15-19	2 301	1 184	1 117
20-24	13 687	8 018	5 669
25-29	50 026	34 617	15 409
30-34	87 771	65 337	22 434
35-39	82 352	61 068	21 284
40-44	77 208	55 678	21 530
45-49	71 399	49 598	21 801
50-54	62 332	41 289	21 043
55-59	57 424	36 278	21 146
60-64	40 555	24 330	16 225
65-69	24 636	13 529	11 107
70+	36 591	18 005	18 586
ХӨДӨӨ-БҮГД	291 145	232 553	58 592
15-19	849	632	217
20-24	9 242	7 952	1 290
25-29	25 355	22 483	2 872
30-34	34 674	30 961	3 713
35-39	37 325	33 155	4 170
40-44	37 760	32 895	4 865
45-49	35 703	29 867	5 836
50-54	31 616	24 875	6 741
55-59	27 869	20 438	7 431
60-64	19 804	13 208	6 596
65-69	12 103	7 092	5 011
70+	18 845	8 995	9 850

Хүснэгт 4. Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, гэрлэлтийн байдал, хот, хөдөөгөөр, 2020 он

Гэрлэлтийн байдал	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
УЛСЫН ДҮН	105 592	14 620	90 972	77583	10 024	67 559	28 009	4596	23 413
Огт гэрлээгүй	28 794	2 857	25 937	22 161	2 221	19 940	6 633	636	5 997
Тусгаарласан	10 080	1 601	8 479	8 094	1 140	6 954	1 986	461	1 525
Цуцалсан	11 303	1 687	9 616	8 729	1 131	7 598	2 574	556	2 018
Бэлэвсэн	55 415	8 475	46 940	38 599	5 532	33 067	16 816	2 943	13 873

Хүснэгт 5. Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2020 он

Насны бүлэг	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
УЛСЫН ДҮН	105 592	14 620	90 972	77583	10 024	67 559	28 009	4596	23 413
15-19	226	64	162	190	57	133	36	7	29
20-24	2 530	249	2 281	1 926	168	1 758	604	81	523
25-29	6 959	721	6 238	5 591	542	5 049	1 368	179	1 189
30-34	8 456	954	7 502	6 713	715	5 998	1 743	239	1 504
35-39	8 831	944	7 887	6 567	623	5 944	2 264	321	1 943
40-44	10 759	1 255	9 504	7 805	833	6 972	2 954	422	2 532
45-49	12 407	1 611	10 796	8 756	1 039	7 717	3 651	572	3 079
50-54	13 347	1 840	11 507	9 320	1 171	8 149	4 027	669	3 358
55-59	13 536	1 960	11 576	9 598	1 291	8 307	3 938	669	3 269
60-64	10 558	1 670	8 888	7 525	1 104	6 421	3 033	566	2 467
65-69	6 981	1 074	5 907	5 133	762	4 371	1 848	312	1 536
70-74	4 400	727	3 673	3 383	534	2 849	1 017	193	824
75-79	3 492	772	2 720	2 691	596	2 095	801	176	625
80-84	1 872	451	1 421	1 430	344	1 086	442	107	335
85-89	936	243	693	709	174	535	227	69	158
90-94	234	68	166	190	57	133	44	11	33
95-99	62	16	46	51	13	38	11	3	8
100+	6	1	5	5	1	4	1	-	1

Хүснэгт 6. Өрх толгойлсон эцэг, эхийн тоо, боловсролын түвшин, хот, хөдөөгөөр, 2020 он

Боловсролын түвшин	Бүгд			Хот			Хөдөө		
	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх	Бүгд	Эцэг	Эх
УЛСЫН ДҮН	105 592	14 620	90 972	77583	10 024	67 559	28 009	4596	23 413
Боловсролгүй	2 477	382	2 095	1 170	176	994	1 307	206	1 101
Бага	9 525	1 576	7 949	3 617	487	3 130	5 908	1 089	4 819
Суурь	16 327	3 074	13 253	7 917	1 408	6 509	8 410	1 666	6 744
Бүрэн дунд	33 461	4 780	28 681	27 615	3 909	23 706	5 846	871	4 975
Техникийн болон мэргэжлийн	5 538	934	4 604	3 907	630	3 277	1 631	304	1 327
Тусгай мэргэжлийн дунд	9 504	1 026	8 478	7 988	847	7 141	1 516	179	1 337
ДЭЭД	28 760	2 848	25 912	25 369	2 567	22 802	3 391	281	3 110
Дипломын дээд	2 376	366	2 010	2 149	354	1 795	227	12	215
Бакалаврын дээд	23 505	2 275	21 230	20 555	2 012	18 543	2 950	263	2 687
Магистр	2 656	168	2 488	2 443	162	2 281	213	6	207
Доктор	223	39	184	222	39	183	1	-	1

Хүснэгт 7. Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настай хүн, хүйсээр, хувиар, хүйсийн харьцаа,
2003-2020 он

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа	Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа
Бүгд	17 966	100.0		Бүгд	24 531	100.0	
2003 Эрэгтэй	6 316	35.2	54.2	2012 Эрэгтэй	7 490	30.5	44.0
Эмэгтэй	11 650	64.8		Эмэгтэй	17 041	69.5	
Бүгд	18 492	100.0		Бүгд	27 622	100.0	
2004 Эрэгтэй	6 429	34.8	53.3	2013 Эрэгтэй	8 620	31.2	45.4
Эмэгтэй	12 063	65.2		Эмэгтэй	19 002	68.8	
Бүгд	17 700	100.0		Бүгд	27 066	100.0	
2005 Эрэгтэй	5 753	32.5	48.2	2014 Эрэгтэй	8 262	30.5	43.9
Эмэгтэй	11 947	67.5		Эмэгтэй	18 804	69.5	
Бүгд	17 622	100.0		Бүгд	33 007	100.0	
2006 Эрэгтэй	5 560	31.6	46.1	2015 Эрэгтэй	9 369	28.4	39.6
Эмэгтэй	12 062	68.4		Эмэгтэй	23 638	71.6	
Бүгд	18 102	100.0		Бүгд	34 060	100.0	
2007 Эрэгтэй	5 918	32.7	48.6	2016 Эрэгтэй	9 294	27.3	37.5
Эмэгтэй	12 184	67.3		Эмэгтэй	24 766	72.7	
Бүгд	20 013	100.0		Бүгд	37 892	100.0	
2008 Эрэгтэй	6 362	31.8	46.6	2017 Эрэгтэй	10 234	27.0	37.0
Эмэгтэй	13 651	68.2		Эмэгтэй	27 658	73.0	
Бүгд	22 366	100.0		Бүгд	39 620	100.0	
2009 Эрэгтэй	7 203	32.2	47.5	2018 Эрэгтэй	10 346	26.1	35.3
Эмэгтэй	15 163	67.8		Эмэгтэй	29 274	73.9	
Бүгд	23 174	100.0		Бүгд	39 501	100.0	
2010 Эрэгтэй	7 295	31.5	45.9	2019 Эрэгтэй	10 421	26.4	35.8
Эмэгтэй	15 879	68.5		Эмэгтэй	29 080	73.6	
Бүгд	23 144	100.0		Бүгд	41 666	100.0	
2011 Эрэгтэй	7 279	31.5	45.9	2020 Эрэгтэй	11 028	26.5	36.0
Эмэгтэй	15 865	68.5		Эмэгтэй	30 638	73.5	

Хүснэгт 8. Нас баралт, хүйс, хувиар, нас баралтын хүйсийн харьцаа, сонгосон онуудаар

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа	Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа
1934 Бүгд	8 991	100.0		2004 Бүгд	16 404	100.0	
Эрэгтэй	4 369	48.6	94.5	Эрэгтэй	9 917	60.5	152.9
Эмэгтэй	4 622	51.4		Эмэгтэй	6 487	39.5	
1940 Бүгд	15 906	100.0		2005 Бүгд	16 480	100.0	
Эрэгтэй	8 072	50.7	103.0	Эрэгтэй	10 006	60.7	154.6
Эмэгтэй	7 834	49.3		Эмэгтэй	6 474	39.3	
1951 Бүгд	7 598	100.0		2006 Бүгд	16 682	100.0	
Эрэгтэй	3 852	50.7	102.8	Эрэгтэй	9 954	59.7	147.9
Эмэгтэй	3 746	49.3		Эмэгтэй	6 728	40.3	
1955 Бүгд	11 823	100.0		2007 Бүгд	16 259	100.0	
Эрэгтэй	5 955	50.4	101.5	Эрэгтэй	9 876	60.7	154.7
Эмэгтэй	5 868	49.6		Эмэгтэй	6 383	39.3	
1960 Бүгд	10 043	100.0		2008 Бүгд	15 413	100.0	
Эрэгтэй	5 121	51.0	104.0	Эрэгтэй	9 117	59.2	144.8
Эмэгтэй	4 922	49.0		Эмэгтэй	6 296	40.8	
1965 Бүгд	13 072	100.0		2009 Бүгд	16 911	100.0	
Эрэгтэй	6 719	51.4	105.8	Эрэгтэй	9 845	58.2	139.3
Эмэгтэй	6 353	48.6		Эмэгтэй	7 066	41.8	
1970 Бүгд	15 314	100.0		2010 Бүгд	18 293	100.0	
Эрэгтэй	8 040	52.5	110.5	Эрэгтэй	10 781	58.9	143.5
Эмэгтэй	7 274	47.5		Эмэгтэй	7 512	41.1	
1975 Бүгд	14 445	100.0		2011 Бүгд	19 155	100.0	
Эрэгтэй	7 680	53.2	113.5	Эрэгтэй	11 709	61.1	157.3
Эмэгтэй	6 765	46.8		Эмэгтэй	7 446	38.9	
1980 Бүгд	17 331	100.0		2012 Бүгд	17 761	100.0	
Эрэгтэй	9 293	53.6	115.6	Эрэгтэй	10 942	61.6	160.5
Эмэгтэй	8 038	46.4		Эмэгтэй	6 819	38.4	
1985 Бүгд	18 688	100.0		2013 Бүгд	17 247	100.0	
Эрэгтэй	10 160	54.4	119.1	Эрэгтэй	10 279	59.6	147.5
Эмэгтэй	8 528	45.6		Эмэгтэй	6 968	40.4	
1990 Бүгд	17 559	100.0		2014 Бүгд	16 521	100.0	
Эрэгтэй	9 772	55.7	125.5	Эрэгтэй	9 953	60.2	151.5
Эмэгтэй	7 787	44.3		Эмэгтэй	6 568	39.8	
1995 Бүгд	16 794	100.0		2015 Бүгд	17 620	100.0	
Эрэгтэй	9 292	55.3	123.9	Эрэгтэй	10 538	59.8	148.8
Эмэгтэй	7 502	44.7		Эмэгтэй	7 082	40.2	
2000 Бүгд	15 472	100.0		2016 Бүгд	17 763	100.0	
Эрэгтэй	8 683	56.1	127.9	Эрэгтэй	10 662	60.0	150.1
Эмэгтэй	6 789	43.9		Эмэгтэй	7 101	40.0	
2001 Бүгд	15 999	100.0		2017 Бүгд	17 357	100.0	
Эрэгтэй	9 106	56.9	132.1	Эрэгтэй	10 571	60.9	155.8
Эмэгтэй	6 893	43.1		Эмэгтэй	6 786	39.1	
2002 Бүгд	15 472	100.0		2018 Бүгд	17 864	100.0	
Эрэгтэй	8 683	56.1	127.9	Эрэгтэй	10 782	60.4	152.2
Эмэгтэй	6 789	43.9		Эмэгтэй	7 082	39.6	
2003 Бүгд	16 006	100.0		2019 Бүгд	18 403	100.0	
Эрэгтэй	9 499	59.3	146.0	Эрэгтэй	11 349	61.7	160.9
Эмэгтэй	6 507	40.7		Эмэгтэй	7 054	38.3	

Хүснэгт 9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүйсээр, хувиар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүйсийн харьцаа, 2003-2020 он

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа	Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа
2003 Бүгд	60 435	100.0		2012 Бүгд	92 263	100.0	
2003 Эрэгтэй	32 446	53.7	115.9	2012 Эрэгтэй	49 680	53.8	116.7
2003 Эмэгтэй	27 989	46.3		2012 Эмэгтэй	42 583	46.2	
2004 Бүгд	66 225	100.0		2013 Бүгд	96 325	100.0	
2004 Эрэгтэй	35 839	54.1	117.9	2013 Эрэгтэй	52 765	54.8	121.1
2004 Эмэгтэй	30 386	45.9		2013 Эмэгтэй	43 560	45.2	
2005 Бүгд	73 001	100.0		2014 Бүгд	99 573	100.0	
2005 Эрэгтэй	39 345	53.9	116.9	2014 Эрэгтэй	54 864	55.1	122.7
2005 Эмэгтэй	33 656	46.1		2014 Эмэгтэй	44 709	44.9	
2006 Бүгд	71 053	100.0		2015 Бүгд	101 730	100.0	
2006 Эрэгтэй	38 129	53.7	115.8	2015 Эрэгтэй	56 434	55.5	124.6
2006 Эмэгтэй	32 924	46.3		2015 Эмэгтэй	45 296	44.5	
2007 Бүгд	71 908	100.0		2016 Бүгд	100 993	100.0	
2007 Эрэгтэй	38 907	54.1	117.9	2016 Эрэгтэй	55 758	55.2	123.3
2007 Эмэгтэй	33 001	45.9		2016 Эмэгтэй	45 235	44.8	
2008 Бүгд	76 369	100.0		2017 Бүгд	103 630	100.0	
2008 Эрэгтэй	41 177	53.9	117.0	2017 Эрэгтэй	57 310	55.3	123.7
2008 Эмэгтэй	35 192	46.1		2017 Эмэгтэй	46 320	44.7	
2009 Бүгд	80 796	100.0		2018 Бүгд	105 730	100.0	
2009 Эрэгтэй	43 717	54.1	117.9	2018 Эрэгтэй	59 691	56.5	129.7
2009 Эмэгтэй	37 079	45.9		2018 Эмэгтэй	46 039	43.5	
2010 Бүгд	82 631	100.0		2019 Бүгд	107 075	100.0	
2010 Эрэгтэй	44 697	54.1	117.8	2019 Эрэгтэй	61 095	57.1	132.9
2010 Эмэгтэй	37 934	45.9		2019 Эмэгтэй	45 980	42.9	
2011 Бүгд	86 865	100.0		2020 Бүгд	106 363	100.0	
2011 Эрэгтэй	46 965	54.1	117.7	2020 Эрэгтэй	58 947	55.4	124.3
2011 Эмэгтэй	39 900	45.9		2020 Эмэгтэй	47 416	44.6	

Хүснэгт 10. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид, хүйс, боловсролын зэргээр,
2002-2019 он

Он	Бүгд			Бакалавр			Магистрантур			Докторантур		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
2002	98 453	37 003	61 450	93 204	35 002	58 202	3 661	1 356	2 305	1 588	645	943
2003	108 738	41 554	67 184	102 632	39 250	63 382	4 491	1 639	2 852	1 615	665	950
2004	123 824	47 775	76 049	116 950	45 399	71 551	5 084	1 675	3 409	1 790	701	1 089
2005	138 019	54 238	83 781	130 413	51 451	78 962	5 626	1 956	3 670	1 980	831	1 149
2006	142 411	56 228	86 183	134 026	53 177	80 849	6 286	2 171	4 115	2 099	880	1 219
2007	150 326	58 606	91 720	141 063	55 350	85 713	7 153	2 405	4 748	2 110	851	1 259
2008	161 111	63 315	97 796	149 399	59 052	90 347	9 505	3 377	6 128	2 207	886	1 321
2009	164 773	65 301	99 472	152 009	60 780	91 229	10 621	3 688	6 933	2 143	833	1 310
2010	170 126	68 671	101 455	155 657	63 406	92 251	12 050	4 317	7 733	2 419	948	1 471
2011	172 798	71 241	101 557	154 876	64 649	90 227	14 873	5 368	9 505	3 049	1 224	1 825
2012	175 591	73 164	102 427	155 801	65 698	90 103	16 630	6 210	10 420	3 160	1 256	1 904
2013	174 075	72 292	101 783	152 708	64 309	88 399	18 063	6 626	11 437	3 304	1 357	1 947
2014	178 295	75 775	102 520	155 839	67 382	88 457	19 065	6 962	12 103	3 391	1 431	1 960
2015	162 626	68 952	93 674	140 296	60 506	79 790	19 005	7 048	11 957	3 325	1 398	1 927
2016	157 138	65 612	91 526	133 223	56 470	76 753	20 066	7 514	12 552	3 849	1 628	2 221
2017	155 248	65 154	90 094	130 608	55 704	74 904	20 345	7 648	12 697	4 295	1 802	2 493
2018	157 625	64 073	93 552	130 907	54 322	76 585	22 499	7 945	14 554	4 219	1 806	2 413
2019	148 446	57 873	90 573	119 301	47 665	71 636	25 753	8 687	17 066	3 392	1 521	1 871

Хүснэгт 11. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үндсэн багш, хүйсээр, хувиар, хүйсийн харьцаа, 2000-2020 он

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа	Үзүүлэлтүүд	Тоо	Хувь	Хүйсийн харьцаа
Бүгд	868	100.0		Бүгд	2 093	100.0	
2000 Эрэгтэй	356	41.0	69.5	2011 Эрэгтэй	763	36.5	57.4
Эмэгтэй	512	59.0		Эмэгтэй	1 330	63.5	
Бүгд	843	100.0		Бүгд	2 236	100.0	
2001 Эрэгтэй	336	39.9	66.3	2012 Эрэгтэй	775	34.7	53.0
Эмэгтэй	507	60.1		Эмэгтэй	1 461	65.3	
Бүгд	955	100.0		Бүгд	2 498	100.0	
2002 Эрэгтэй	404	42.3	73.3	2013 Эрэгтэй	890	35.6	55.3
Эмэгтэй	551	57.7		Эмэгтэй	1 608	64.4	
Бүгд	1 098	100.0		Бүгд	2 327	100.0	
2003 Эрэгтэй	411	37.4	59.8	2014 Эрэгтэй	830	35.7	55.4
Эмэгтэй	687	62.6		Эмэгтэй	1 497	64.3	
Бүгд	1 160	100.0		Бүгд	2 504	100.0	
2004 Эрэгтэй	427	36.8	58.3	2015 Эрэгтэй	883	35.3	54.5
Эмэгтэй	733	63.2		Эмэгтэй	1 621	64.7	
Бүгд	1 141	100.0		Бүгд	2 510	100.0	
2005 Эрэгтэй	429	37.6	60.3	2016 Эрэгтэй	936	37.3	59.5
Эмэгтэй	712	62.4		Эмэгтэй	1 574	62.7	
Бүгд	1 286	100.0		Бүгд	2 230	100.0	
2006 Эрэгтэй	483	37.6	60.1	2017 Эрэгтэй	861	38.6	62.9
Эмэгтэй	803	62.4		Эмэгтэй	1 369	61.4	
Бүгд	1 451	100.0		Бүгд	2 469	100.0	
2007 Эрэгтэй	545	37.6	60.2	2018 Эрэгтэй	905	36.7	57.9
Эмэгтэй	906	62.4		Эмэгтэй	1 564	63.3	
Бүгд	1 667	100.0		Бүгд	2 388	100.0	
2008 Эрэгтэй	610	36.6	57.7	2019 Эрэгтэй	837	35.1	54.0
Эмэгтэй	1 057	63.4		Эмэгтэй	1 551	64.9	
Бүгд	2 033	100.0		Бүгд	2 242	100.0	
2009 Эрэгтэй	777	38.2	61.9	2020 Эрэгтэй	809	36.1	56.5
Эмэгтэй	1 256	61.8		Эмэгтэй	1 433	63.9	
Бүгд	2 143	100.0					
2010 Эрэгтэй	812	37.9	61.0				
Эмэгтэй	1 331	62.1					

Хүснэгт 12. Бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчид, хүйсээр, хувиар, 2000-2020 он

	Үзүүлэлтүүд	Тоо	Хувь		Үзүүлэлтүүд	Тоо	Хувь
2000	Бүгд	20 352	100.0	2011	Бүгд	17 982	100.0
	Эрэгтэй	18 718	92.0		Эрэгтэй	15 679	87.2
	Эмэгтэй	1 634	8.0		Эмэгтэй	2 303	12.8
2001	Бүгд	21 100	100.0	2012	Бүгд	19 734	100.0
	Эрэгтэй	19 357	91.7		Эрэгтэй	17 067	86.5
	Эмэгтэй	1 743	8.3		Эмэгтэй	2 667	13.5
2002	Бүгд	19 445	100.0	2013	Бүгд	22 286	100.0
	Эрэгтэй	17 722	91.1		Эрэгтэй	19 149	85.9
	Эмэгтэй	1 723	8.9		Эмэгтэй	3 137	14.1
2003	Бүгд	17 641	100.0	2014	Бүгд	23 737	100.0
	Эрэгтэй	16 126	91.4		Эрэгтэй	20 119	84.8
	Эмэгтэй	1 515	8.6		Эмэгтэй	3 618	15.2
2004	Бүгд	17 044	100.0	2015	Бүгд	24 857	100.0
	Эрэгтэй	15 472	90.8		Эрэгтэй	21 075	84.8
	Эмэгтэй	1 572	9.2		Эмэгтэй	3 782	15.2
2005	Бүгд	16 369	100.0	2016	Бүгд	23 805	100.0
	Эрэгтэй	14 763	90.2		Эрэгтэй	20 213	84.9
	Эмэгтэй	1 606	9.8		Эмэгтэй	3 592	15.1
2006	Бүгд	16 825	100.0	2017	Бүгд	18 131	100.0
	Эрэгтэй	15 173	90.2		Эрэгтэй	15 599	86.0
	Эмэгтэй	1 652	9.8		Эмэгтэй	2 532	14.0
2007	Бүгд	17 810	100.0	2018	Бүгд	16 389	100.0
	Эрэгтэй	15 931	89.4		Эрэгтэй	14 171	86.5
	Эмэгтэй	1 879	10.6		Эмэгтэй	2 218	13.5
2008	Бүгд	18 642	100.0	2019	Бүгд	17 110	100.0
	Эрэгтэй	16 580	88.9		Эрэгтэй	14 823	86.6
	Эмэгтэй	2 062	11.1		Эмэгтэй	2 287	13.4
2009	Бүгд	19 612	100.0	2020	Бүгд	16 667	100.0
	Эрэгтэй	17 535	89.4		Эрэгтэй	13 760	82.6
	Эмэгтэй	2 077	10.6		Эмэгтэй	2 907	17.4
2010	Бүгд	19 378	100.0				
	Эрэгтэй	16 996	87.7				
	Эмэгтэй	2 382	12.3				

Хүснэгт 13. Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо, хүйсээр, хувиар, 2000-2020

Үзүүлэлтүүд			Үзүүлэлтүүд				
	Тоо	Хувь		Тоо	Хувь		
2000	Бүгд	14 234	100.0	2010	Бүгд	7 292	100.0
	Эрэгтэй	13 229	92.9		Эрэгтэй	6 680	91.6
	Эмэгтэй	1 005	7.1		Эмэгтэй	612	8.4
2001	Бүгд	13 581	100.0	2011	Бүгд	8 210	100.0
	Эрэгтэй	12 493	92.0		Эрэгтэй	7 486	91.2
	Эмэгтэй	1 088	8.0		Эмэгтэй	724	8.8
2002	Бүгд	11 357	100.0	2012	Бүгд	8 324	100.0
	Эрэгтэй	10 498	92.4		Эрэгтэй	7 598	91.3
	Эмэгтэй	859	7.6		Эмэгтэй	726	8.7
2003	Бүгд	9 029	100.0	2013	Бүгд	8 065	100.0
	Эрэгтэй	8 295	91.9		Эрэгтэй	7 373	91.4
	Эмэгтэй	734	8.1		Эмэгтэй	692	8.6
2004	Бүгд	9 473	100.0	2014	Бүгд	8 178	100.0
	Эрэгтэй	8 738	92.2		Эрэгтэй	7 460	91.2
	Эмэгтэй	735	7.8		Эмэгтэй	718	8.8
2005	Бүгд	10 153	100.0	2015	Бүгд	7 696	100.0
	Эрэгтэй	9 277	91.4		Эрэгтэй	7 032	91.4
	Эмэгтэй	876	8.6		Эмэгтэй	664	8.6
2006	Бүгд	7 792	100.0	2016	Бүгд	6 566	100.0
	Эрэгтэй	7 132	91.5		Эрэгтэй	6 048	92.1
	Эмэгтэй	660	8.5		Эмэгтэй	518	7.9
2007	Бүгд	8 463	100.0	2017	Бүгд	9 019	100.0
	Эрэгтэй	7 753	91.6		Эрэгтэй	8 086	89.7
	Эмэгтэй	710	8.4		Эмэгтэй	933	10.3
2008	Бүгд	8 495	100.0	2018	Бүгд	12 088	100.0
	Эрэгтэй	7 696	90.6		Эрэгтэй	11 793	97.6
	Эмэгтэй	799	9.4		Эмэгтэй	295	2.4
2009	Бүгд	7 513	100.0	2019	Бүгд	13 011	100.0
	Эрэгтэй	6 857	91.3		Эрэгтэй	11 568	88.9
	Эмэгтэй	656	8.7		Эмэгтэй	1 443	11.1

Хүснэгт 14. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, хүйсээр, зарим насны бүлгээр, 2014-2020 он

Он	Бүгд			Хүйсийн харьцаа	7 болон түүнээс доош насны хүүхдийн тоо	8-17 насны хүүхдийн тоо
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй			
2014	27 475	16 573	10 902	152.0	205	1 371
2015	27 948	20 120	7 828	257.0	201	1 276
2016	27 689	19 693	7 996	246.3	208	1 132
2017	37 173	22 455	14 718	152.6	211	1 546
2018	33 566	18 893	14 673	128.8	173	1 515
2019	30 782	17 577	13 205	133.1	208	1 390
2020	23 050	13 629	9 421	144.7	155	1 026